

**ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА**





## МОНГОЛ УЛСЫН ГАДААД НЭР ХҮНДЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ДОТООД ОРЧНЫ АЮУЛ

Д.Уламбаяр\*  
Т.Уянга\*\*

***Abstract:** This article talking about an analysis in the homeland security environment impact in Mongolia's Foreign Reputation. Such as rule of law, supply chain connectivity of good governance, sustainable development, quality of life, human rights guarantees, equality, honesty, limiting state power, Mongolia's landlocked status, changing geopolitical environment, a new geostrategic assessment on mongolia's geographical location, building of multi-pillared economic fundament, equal division of natural wealth, transprance initiative in minig sectors, inflation and export's force challenges, unbalanced state budget policy, domestic migration issues, global warming and climate change impact in livestock and agro farming. Also digitization and job opportunities, money laundering and corruption.*

***Key words:** homeland security, democracy, governance, parliament, strategic raw materials, natural wealth, natural resource curse, economic hit men, inflation, foreign debt, digitization, money laundering, grey list, sustainable development, etc.,*

\*\*\*

Аливаа улсын дотоод, гадаад бодлого нь хоорондоо диалектик нэгдэлтэй байдаг агаад тиймдээ ч гадаад бодлого бол дотоод бодлогын шууд үргэлжлэл гэж үзэх нь буй. Ардчилсан дэглэмтэй, зүгширсэн зах зээлийн механизм бүхий эдийн засагтай, амжиргааны түвшин хангалуун улс орны дотоод бодлого нь гадаад бодлогодоо илүү эерэг зөөлөн нөлөө үзүүлдэг. Чингэхдээ үүнийг туйлчлан авч үзвэл ихээхэн учир дутагдалтай гэдэг нь мэдээж билээ. Учир нь АНУ-ыг энэ үүднээс авч үзэх боломжгүй юм. Азийн шинээр аж үйлдвэржсэн бар улс орнууд, дэлхийн санхүүгийн төв болж чадсан булангийн Арабын нэгдсэн Эмират, 2022 онд дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах Катар улс бол дотоодын асуудлаа амжилттай шийдвэрлэж, тийнхүү гадаад нэр хүндээ өсгөсөөр буй нь аяндаа зөөлөн татах хүчийг буй болгож байгаа хэрэг мөн билээ.

Монгол Улсын хөгжил дэвшил, аюулгүй байдал гадаад орчин гэхээсээ илүүтэй гол нь дотоод орчин, төв мэдрэлийн систем, динамикаасаа шалтгаалж буй нь

\* ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

\*\* ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн докторант

хэдийнээ тодорхой болчихсон зүйл билээ. Суурь шалтгааныг дараах шалтгаанаар авч үзэж болно.

**Нэгд**, Монгол Улсын гадаад, дотоод орчин сүүлийн 20 жил бус, бүр арван жилийн өмнөхөөсөө өөрчлөгдөж, тийнхүү үндэсний аюулгүй байдлаа зөвхөн улс төр-дипломатын аргаар хангах нь өрөөсгөл хандлага болсон бөгөөд харилцан шүтэлцээтэй дэлхий ертөнцөд том, жижиг аль ч улс орнуудын өмнө сайн засаглал, тогтвортой хөгжил, амьдралын чанар тэргүүн зэрэгт тавигдаж, ингэхлээрээ үндэсний аюулгүй байдлаа эдийн засгийн арга замаар хангах тухай асуудлыг оройд нь тавьж байгаа билээ. Хууль дээдлэх, шударга ёсыг хэлбэрэлтгүй сахих, ухаалаг засаглалыг цогцлоох, хүний эрхийн баталгааг хангах, төрийн эрх мэдлийг хязгаарлах зэрэг ардчилалын чанарын асуудал амин чухал болж байна.

Аюулгүй байдлын асуудал улам бүр хүний аюулгүй байдал дээр төвлөрлөх болов. Хүний эрхийг дээдлэх, шударга ёсыг хэрэгжүүлэх, ардчилал, амьдралын чанарыг сайжруулах нь хүний аюулгүй байдлын баталгааг хангахын чухал нөхцөл мөн. Үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал нэн чухал гэдэг нь тодорхой билээ.

**Хоёрт**, Монгол Улс буурай хөгжилтэй, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, цөмийн зэвсэгтэй хоёр гүрний дунд орших боловч монгол угсаатнаар хүрээлэгдсэн онцлогтой, эдүгээ дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт багтаж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний арвин нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, гео-эдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулах болов.

**Далайд гарцгүй Монгол Улсын туйлын сул талыг өөрийнх нь байгалийн баялаг, үсрэнгүй хөгжиж буй Хятадын эдийн засгийн эрэлт хэрэгцээ, Орос, Хятадын иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл, Монголын геополитикийн орон зай, газарзүйн байрилын геостратегийн шинэ үнэлгээ харьцангуй давуу талыг буй болгож, эерэг тийш нь аажим боловч өөрчилсөөр буйг онцлон дурдах ёстой.**

Монгол Улс XXI зуун гарснаас хойш сүүлийн хорин жилийн хөгжилд шийдвэрлэх алхам хийсэн ч эдийн засаг, ардчилал, сайн засаглал, хүний эрхийн баталгаажилт, сонгуулийн тогтолцоо бүрэн зүгширч төлөвшөөгүй, харин ч ихээхэн эмзэг, сул, түүнчлэн ДНБ 2000 оноос хойш хэдэн арав дахин өссөн (ДНБ nominal үнэлгээгээр 2000 онд 250 гаруй сая ам. доллар байсан<sup>3</sup> бол 2018 онд 13.7 тэрбум ам. доллар болов.<sup>4</sup>) боловч иргэдийн орлого тэр хэмжээгээр өсөөгүйгээр үл барам ядуурал улам бүр нэмэгдсэн нь улс төр-эдийн засгийн одоогийн тогтолцоо хийгээд бодлого ихээхэн гаж явж ирснийг харуулна. Дээрх тоон үзүүлэлтийг үндэслэн тооцвол онолын хувьд, төсвийн ажилтны дундаж цалин 2000 онд 260 мянган

<sup>3</sup> <https://www.ceicdata.com/en/indicator/mongolia/nominal-gdp>

<sup>4</sup> IMF.org. International Monetary Fund. Retrieved February 24, 2019.

төгрөг байсан бол 2018 онд дундажаар 2.6 сая төгрөг болохоор байв. Гэвч цалин хөлс ингэж өссөнгүй. Үндэсний Статистикийн Хороо болон Дэлхийн Банк хамтран 2019 оны 6 дугаар сард тайлагнасан ядуурлын тооцооны үр дүнг авч үзвэл<sup>5</sup> Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь байсан бол 2018 онд 28.4 хувь болж, 1.2 пунктээр буурчээ. Хүн амын хэрэглээ ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлдэг ядуурлын гүнзгийрэлт 2018 онд 7.2 хувь болж, 2016 оныхоос 0.5 пунктээр буурсан бол ядуучуудын тэгш бус байдлын зэргийг хэмждэг ядуурлын мэдрэмж 2.7 хувь болж, 2016 оныхоос 0.2 пунктээр буурсан байна. Хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл нэмэгдэж байна. Хөдөө орон нутагт 2016-аас 2018 оны хооронд ядуурал 4.1 пунктээр буурсан бол хотод 0.1 пунктээр нэмэгдсэн байна. Хөдөө орон нутагт ядуурлын түвшин өндөр хэвээр байгаа боловч Монгол Улсын нийт хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдарч байгаагаас ядуурал хот суурин газарт нэмэгдэж байна. Хот суурин газарт амьдарч буй ядуусын эзлэх хувь 2016 онд 62.1 байсан бол 2018 онд 63.5 болсон бөгөөд Улаанбаатар хотод 2018 оны байдлаар нийт ядуусын 41.8 хувь нь амьдарч байна. Бүс нутгийн хувьд авч үзэхэд Зүүн бүсэд ядуурал 6.6 пунктээр, Баруун бүсэд 4.3 пунктээр, Хангайн бүсэд 2.7 пунктээр, харин Төвийн бүсэд ядуурлын түвшин 0.7 пунктээр буурсан бол Улаанбаатар хотод 1.1 пунктээр нэмэгдсэн байна.

Өөр ноцтой асуудал бол ардчилал, төр засаглалын тогтолцоо өөрөө системийн гүн хямралд орсон нь үндэсний аюулгүй байдлыг ихээхэн хэврэг болгож мэдэхээр байгаа юм. Үүнд юуны өмнө сонгуулийн эрхзүйн тогтолцоо, хамтарсан болон шинэчлэлийн Засгийн газарт хамтарч тохиролцох, үгсэн хуйвалдах, засаглалын тогтолцоо алдагдаж нам төвтэй төрийн үйл ажиллагаа болсон, орлого, хууль, засаглалын тэгш бус хуваарилалт, мөнгөний томилогоо, хүний эрх бүдүүлгээр зөрчих, хариуцлага тооцох тогтолцоо, шүүх, прокурор, тагнуул, АТГ-ын хараат бус байдал алдагдсан, төр эрх мэдлээ хэтрүүлэх зэрэг хамаарна.

Монгол Улс Үндсэн хуулийн ёсоор парламентын засаглалтай боловч ерөнхийлөгчийн институцитай зөрчилддөг байдлыг Үндсэн хуулийн хүрээнд хууль, эрхзүйн хувьд тодотгож, тодорхой зааглах шаардлагатай. Өөрөөр хэлбэл төрийн эрх мэдлийг зааглаж, чиг үүргийн давхардлыг арилгаж, ялгааг тодорхой болгох явдал юм.

Хүний эрх, ардчилалыг дэлхий дахинд сурталдаж, зааж зааварлаж байх цаг дор Монголд хүний эрхийг хөсөрдүүлж, эрүүдэн шүүж, хилсээр хэлмэгдүүлж байсан нь туйлын гутамшигтай. Шүүх, прокурор, тагнуулын байгууллага нь бие биендээ барьцаалагдаж, тодорхой схемээр ажилладаг байсан нь тодорхой болсоор «шударга бусын хонгил» гэж байдаг бололтой. Ардчилсан Үндсэн хуулийн алтан зарчим нь гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнбугуйг ч буруутайд тооцож үл болох тухай хүний эрхийг дээдлэсэн заалт бөгөөд үүнийг иргэд сайн мэддэг. Баривчлахад хүртэл эрхийг нь сануулдаг жамтай.

<sup>5</sup> Үндэсний Статистикийн Хороо. Мэдээлэл: 2019.06.21

Улс төрчид олигархиудын барьцаанд орлоо хэмээн иргэд байтугай эрхэм гишүүд өөрсдөө ихээхэн ярьж хэлэх дуртай. Олигархи гэдэг нь эдийн засгийн сонгодог утгаараа банкны эзэд, үйлдвэр-худалдааны бүлгийнхэнтэй нэгдсэний дүнд буй болсон бизнесийн цөөн эздийн монопольт хамсал юм. Харин энэхүү монопольт нэгдэл улс төрчидтэй хэлхэлдсэнээр олигополийг буй болгодог. Үнэхээр Монголын төр олигополь шинжтэй болоод зогсохгүй бие биеийнхээ барьцаанд орчихоод байгаа билээ. Өнөөгийн төрд ариун явдалтан хуруу дарамд багтах агаад харин хэн нь бага, хэн нь их идсэн гэдэгт л асуудлын мөн чанар оршино хэмээн бичиж буй нь үнэнд ойрхон болой. Монголд ДНБ болон улсын төсөв хэд дахин өссөн хэрнээ иргэдийн амьжиргааны түвшин дээшлэхгүй, ядуурал ихэссээр байхад энэ их мөнгө хаашаа урсаад байгаа нь хачирхалтай. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 75 орчим хувь нь лиценз хэлбэрээр гадаадынхны эзэмшилд орсон нь тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал ямаршуухан түвшинд байсныг харуулж байсан билээ.

МАН-ын албан тушаалын томилогооны 60 тэрбумийн схем нь АН-ын дэнчингийн схемтэй агаар нэгэн болой. Ах нам гэж өөрсдийг өргөмжилсөн МАН-ын дотоод дахь хагарал, УИХ, Засгийн газрын тэргүүн нарын тэмцэл, ардчилалын алтан хараацай гэж өөрсдийгөө өргөмжилсөн АН УИХ-д бүлэггүй болтлоо хумигдаж, хагарал сөргөлдөөн тэднийг тойрон гарсангүй.

Ганцхан уул уурхайн хөгжил Монгол Улсыг аварна хэмээн хошуурч, хошигруулж байсан үед үүнийг дагаад асар их хэмжээний мөнгөний үнэр ханхалж, улс төрчид, бизнесийн бүлэглэлийн хүсэл тачаалыг эрхгүй татсан нь бодит үнэн юм. Тийнхүү хамгийн томоор идэж уух, 76 авлигач, төрөөс төрсөн тэрбумтан, олигархи төр хэмээн цоллуулах болов. Хамтарсан Засгийн газар гэдэг нь хамтаар үгсэн хуйвалдаж идэж уухийг хэлнэ гэсэн тодотгол хүртэл гарч байсан. Энэ нь гүнзгийрсээр «МАНАН» бүлэглэл болтлоо хөгжин цэцэглэжээ. Ер нь цаашдаа УИХ-ын гишүүнд төрийн албанд сүүлийн гурав эсвэл таваас доошгүй жил ажилласан хүнийг дэвшүүлдэг баймаар санагддаг.

Төр засаглалийн гол гацаа нь УИХ-ын 76 гишүүдийн тоо цөөн, 3.2 сая хүн амыг төлөөлж чадахгүй, бүрэн эрхийн хугацаа болох 4 жил нь ажил хийхэд багадаад байгаадаа биш гэдэг нь судалгаанаас маш тодорхой харагддаг билээ. УИХ 100 илүү гишүүнтэй болсон тохиолдолд 30-40 гаруй нь лавтай хуралдаа суухгүй байхад л УИХ ажлаа явуулаад байх магадлалтай. УИХ-ын гишүүнд эхний жилдээ шинэ ажилтайгаа танилцдаг, сүүлийн жилд нь дараагийн сонгуульдаа бэлтгэдэг газар биш гэдгийг хатуу ойлгуулах ёстой.

УИХ-ын гишүүн нь бодлогын чиг үүрэгтэй яамдаас бусад яамдын сайдыг давхар хашиж үл болох хийгээд мөн ч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн чиг үүргийг нарийн тодорхойлох, дипломат албаны тухай хуулинд элчин сайд, дипломат албаны ажилтан нарын томилох, эгүүлэн татах процедурыг нарийн зүйлчилж өгөх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Монгол Улс хар тамхи, мансууруулах бодисын хууль бус наймааны дамжин өнгөрөх зангилаа байсан бол улмаар хэрэглэгч зах зээл болж, цаашлаад хар тамхины бизнесийг дипломатчид нь

гардан хийдэг болтлоо цэцэглэн хөгжих болжээ.

«Намын лидерүүд» гэж өөрсдийгөө өргөмжилсөн эрхэмүүдэд авлига, хахууль өгч сонгуулийн тойрог худалдаж авах, намын жагсаалтад дээгүүр бичигдэх, хандив, өнгө мөнгөний чансаагаар эрэмбэлэгдэж сайд даргад томилогддогийг хуулиар хориглох шаардлагатай. УИХ-ын тойрогт болон намын жагсаалтаар сонгогдсон гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгоогүй байснаас асуудал үүсч байсан бөгөөд УИХ, Засгийн газрын хоорондын эрх, үүргийг маш тодорхой зааглах, үүргээ биелүүлж чадахгүй байгаа УИХ-ын гишүүдэд хариуцлага тооцох хамгийн чухал гарц нь тойргийн сонгогчид нь эгүүлэн татах эрхзүйн орчинг буй болгох явдал бөгөөд улмаар энэ нь сайхь зөөлөн суудал руу тухлах улайрагсад буурах нигууртай.

**Гуравт,** Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг дээшлүүлэх, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бүрдүүлж, салбарын тэнцвэртэй бодлого явуулах шаардлага байгаа нь тодорхой. Гэвч хөдөлмөрийн нөөцийн нэлээд хэсэг уул уурхай, түүний бичил салбар руу шилжсэнээр бусад салбарт ажиллах хүчний хомсдол буй болж, нуугдмал байсан *dutch disease*-ийн хамшинж (*syndrome*) илэрч эхэлсэн билээ.

Харилцан хамаарал гүнзгийрч буй ертөнцөд эдийн засгийн бие даасан байдлыг дангаараа ханган хөгжих боломжгүй ч улс орны эдийн засаг зохих түвшинд харьцангуй олон тулгууртай байх нь гарцаагүй. Нэмүү биш (*surplus value*), харин эдийн засгийн жинхэнэ утгаараа нэмэгдсэн өртөг (*value added*) шингэсэн ховор элемент, нүүрс, өнгөт метал, төмөрлөг, газрын тос боловсруулах зэрэг үйлдвэрлэлжүүлтийн бодлогыг ажил хэрэг болгож, Ази-Европ тивийн хооронд иж бүрэн ложистик хангагдсан «газрын гүүр» болж, үүнийг аялал жуулчлалтай хослуулсан идэвхитэй транзит орон болох боломж буй. Цөмийн эрчим хүчний тухайд баримтлах бодлогыг ч нааштайгаар эргэн харах шаардлагатай болов уу.

**Дөрөвт,** Эдүгээ стратегийн түүхий эд, байгалийн баялгийн монголын ард түмэнд унах өгөөжийн ойрхи ирээдүй тун бүрхэг болоод зогсохгүй сүүлийн зургаан жилийн дотор ихээхэн хэмжээний гадаад өр хуримтлагдсан нь бодитой зүйл болов. Харамсалтай нь өнгөрсөн хугацаанд стратегийн шинжтэй томоохон ганц ч үйлдвэр, эрчим хүчний станц, сургууль, цэцэрлэг, төрөх эмнэлэг ашиглалтад орсонгүй. Хамгийн ноцтой нь байгалийн баялгаа ломбардад тавьснаар үүссэн зээлийн өр үүсчээ. Хүний гараар бүтээгдээгүй Монголын байгалийн их баялаг хэн нэгний бүтээж буй болгосон хувийн өмч биш бөгөөд тиймээс баялагийг хараал болгохгүйн тулд ***ил тод байдлын санаачлагыг ногоон эдийн засагтай нягт уялдуулж*** нийт ард түмэнд тэгш хүртээх нь шударга ёсонд бүрнээ нийцнэ. Баялаг бүтээгч гэж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг нэрлэдэг бөлгөө.

“Оюутолгой”-н баялгийн 66 хувийг барьцаанд тавьж, төслийн гүнийн уурхайн санхүүжилтэд зориулж олон улсын санхүүгийн 5 байгууллага, арилжааны 15 банкнаас шаардлагатай 6 тэрбумаас нийт 4.4 тэрбум ам.долларыг зээлж, хөрөнгө

босгож, үлдсэн 1.6 тэрбум ам.долларыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр болсноо 2014 оны 12 дугаар сард Rio Tinto болон Turquoise Hill Resources компаниас мэдэгдэж байсан. Үүнийг үнэхээр гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж үзэхэд ихээхэн эргэлзээ төрүүлж байна.

Монголын тал Оюутолгойн 34 хувийг эзэмшигч ч төслийн бүтээн байгуулалтад нэг ч төгрөг гаргаагүй. Гэвч баялгаа үнэлүүлж чадаагүй. Баялаг нь Монголынх ч хөрөнгө оруулалтын гэрээний дагуу анхны хөрөнгө оруулалтын 34 хувь нь Монголчуудын эргэн төлөх зээл болоод байна. Уг эх үүсвэрийг хөрөнгө оруулагч талаас жилийн 9 хувийн хүүтэй зээлсэн бөгөөд өнөөгийн үнэ цэнээр өр төлбөр 1 тэрбум ам.долларт хүрчээ. Монголын тал 34 хувьд ногдох санхүүжилтийн зөвхөн зээлийн хүүгийн төлбөрт жилдээ 100-110 сая ам.доллар зарцуулж байгаа ажээ. Ийм байдлаар явсаар Монгол Улс 2032 онд 34 хувьд ногдох зээлийг төлж дуусах төлөвтэй байгаа юм. Монголын тал Оюутолгойн 34 хувьдаа ногдол ашиг хүртэх хугацаа улам бүр хойшилж байгаад санаагаа чилээж, сүүлдээ зарах хувилбарыг хүртэл хөндөж эхэлжээ. Ойрын жилүүдэд бондуудын өр төлбөрүүд хүлээгдэж байгаа учраас Оюутолгойн 34 хувьд ногдох өр зээлийн асуудлыг төлөх асуудал улам л хойшлох магадлалтай байна. Монгол Улс Оюутолгойн 34 хувийг эзэмшдэг нь үнэн, гэхдээ зээлээ төлж байж 34 хувийнхаа эзэн болох нь мөн л үнэн учраас хамгийн багадаа 15 жилийн дараа ногдол ашиг хүртэх эрхтэй болохоор байна. Дубайд Оюутолгойн хөрөнгө оруулагчидтай хэлэлцээ хийсний дараагаар гүний уурхайн зардлын 4.4 тэрбум ам.долларын зээл, анхны хөрөнгө оруулалтын хэтрэлт 1 тэрбум гаруй ам.доллар, 904 сая ам.долларын татварын хөнгөлөлт зэргийг Дубайн гэрээгээр Монгол Улсын Засгийн газар хүлээн зөвшөөрснөөр бидний хүртэх ногдол ашиг анх төлөвлөсөн 2021 оноос 16 жилээр хойшилж, 2037 оны орчимд авахаар болсон бололтой.

2009 оны 10 дугаар сард Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсны дараа тухайн үеийн Ерөнхий сайд С.Баяр “Оюутолгой” төслийн өгөөжтэй холбоотой хэд хэдэн зүйл хэлж байсан. Тухайлбал, “Уурхайн үйл ажиллагаа эхэлснээр Монголын экспортын хэмжээ 2.0-2.5 тэрбум ам.доллараар нэмэгдэж, гадаад валютын улсын нөөц арвижна”, “жилд дунджаар 580 гаруй сая ам.долларын татварын орлого улсын төсөвт орж, төслийн үргэлжлэх хугацаанд нийт татвар, орлого 29 гаруй тэрбум ам.доллараар хэмжигдэж, төсвийн орлогын найдвартай эх үүсвэр буй болж, эдийн засаг, нийгмийн олон чухал асуудлыг шийдвэрлэх таатай нөхцөл бүрдэнэ” гэж байжээ. Оюутолгойн асуудлыг УИХ-аар хэлэлцэхтэй зэрэгцэн гүнийн уурхайн олборлолт 2023 он хүртэл хойшлогдов. Оюутолгойн зэс, алтны уул уурхайн үр шимээр Монгол Улс цэнгэлийн манлайд хүрэх ойрын ирээдүйн төлөв байдал ийнхүү үлгэр болов.

Монголыг тэжээгч гол саалийн үнээ гэгдэх “Эрдэнэт” үйлдвэрийн Оросын талын 49 хувийг худалдан авах эрхээсээ Засгийн газрын тэргүүн нь УИХ-тай үл зөвшилцөн толгой мэдэн сайн дураар татгалзж, үлдсэн 51 хувь нь гадны банкны барьцаанд орсон нь луйврын систем хэрхэн нарийн дэг тогтолцоотой бат бэх



цогцлон хөгжсөн нь харагдана.

1973 оны 11 дүгээр сарын 22-нд “Эрдэнэт” үйлдвэр байгуулах гэрээнд Монголын талаас Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал, Зөвлөлтийн талаас Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга И.Т.Новиков нар гарын үсэг зурсан байдаг. Тийнхүү баяжуулах үйлдвэрийн өртөг нь 1 тэрбум шилжих рубль болж хагасыг нь Монголын талд зээлдүүлж, түүнийгээ зэсийн баяжмалаар авахаар тохиролцож байжээ. Баяжуулах үйлдвэр байгуулахтай зэрэгцэн 1976 онд Зууны манлай бүтээн байгуулалт болох Эрдэнэт хотын үндэс суурийг тавьж, 10 жилийн дараа цэцэглэн хөгжсөн Монгол Улсын гуравдахь том хот болтлоо хөгжиж иржээ. Гэтэл Оюутолгой төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 10 жил өнгөрчихөөд байхад хэдхэн сэндвичэн барилгаас өөр юу ч босгосонгүй. Эрчим хүчний станц ч тэр нэг адил болой.

1978 онд Монгол, Зөвлөлтийн Засгийн газар хоорондын гэрээний дагуу “Эрдэнэтийн овоо”-ны орд газарт уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр байгуулагдсан түүхтэй билээ. 1978 онд анхны баяжмал гарган авч, жилд 4 сая тонн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадал бүхий уулын баяжуулах үйлдвэрийн эхний ээлжийг ашиглалтанд оруулав. 1980 онд жилд 8 сая тонн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэрийн хоёрдугаар ээлжийг ашиглалтанд оруулав. 1981 онд үйлдвэрийн дөрөвдүгээр ээлжийг ашиглалтанд оруулж, жилд 16 сая.тонн хүдэр олборлох, боловсруулах хүчин чадалтай болов. 1989 онд уулын баяжуулах үйлдвэрийн тавдугаар ээлжийг ашиглалтанд оруулж, хүдэр олборлох, боловсруулах хүчин чадлыг жилд 20 сая тонн хүртэл нэмэгдүүлсэн байна. Баяжуулах үйлдвэр ашиглалтанд орсноос хойш 1 сая тонн зэсийн агууламжтай баяжмал үйлдвэрлэжээ. Эрдэнэт үйлдвэр 2019 оны байдлаар жилд 26 сая тонн хүдэр боловсруулж 530 орчим мянган тонн зэсийн баяжмал, 4.5 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэж байгаа ажээ. “Эрдэнэт” үйлдвэр 1990-ээд оны шилжилтийн хүндхэн үеийг даван туулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ.

Жин нэмж барилдана хэмээн сагсайж цаг нь болоогүй байхад бэлэн болсон ТЭЗҮ бүхий томоохон нэг ч төсөлгүй Чингис, Самурай болон бусад бонд нэртэй хүү өндөр, хугацаа богино хэрэг дээрээ арилжааны зээл авч, тоймтой гийгүүлсэн бүтээн байгуулалт буй болгож чадалгүй улс орны эдийн засгийг элгээр нь хэвтүүлж, өрөнд баригдав.

Бурханаас заяасан байгалийн их баялгийг байгаль орчинд ээлтэй технологиор олборлож, түүний үр шимээс ард иргэд нь тэгш хүртэж, эко орчин нь тэнцвэрээ хадгалж байх шаардлагатай. Сүүлийн 25 жилд гадаадын хөрөнгө оруулалтад дулдуйдсан уул уурхай эрчимтэй хөгжсөн боловч, ард иргэдэд түүний үр өгөөж хүртээмжгүй явж ирснээр барахгүй дээрхтэй холбоотойгоор хүрээлэн буй орчны доройтол үргэлжилсээр байна. Үүнийг л «баялагийн хараал» (*natural resource curse*) хэмээн нэрлэдэг бөлгөө. Хэт ашгийн хойноос улайрагч гадны үндэстэн дамнасан хөрөнгө оруулагчдын хүсэл шунал, мөн ч олон улсын банк, санхүүгийн

байгууллагын заавар зөвлөмж, үндэсний шинээр төрж буй баяжих нэн сонирхолтой хөрөнгөлөг этгээдүүд (мөн улс төрчид) хоёрын нийлбэрийг эдийн засгийн алуурчид буюу *economic hit men* хэмээх ажгуу. Бурханы хишгийг улс төрийн элдэв амлалттай ямар ч холбогдолгүйгээр ард иргэддээ санаачлагатай хүртээх нь аль ч УИХ, Засгийн газрын стратегийн зорилтот үндсэн ажил байх ёстой.

Шведэд “өгөөмөр төр” гэдэг нэр томьёо гарсан нь иргэний нийгмийн хамгааллын цогцолбор хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн явдалтай холбогддог. Үүгээрээ Швед улс дэлхийд дээгүүр байранд ордог агаад төр, засаг нь хүнийг «өлгийтэйгээс нь булшинд ортол тэжээдэг» гэсэн үг ч гарчээ. «Өгөөмөр төр»-д эрүүлийг хамгаалах, боловсрол олгох, нийгмийн даатгал төдийгүй тэтгэврийн асуудал багтдаг. Тэгэхдээ хүүхэд, хөгшчүүлд илүү анхаарал халамж тавьж байдгын жишээ нь үнэгүй үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж, хичээлийн сурах бичгээр хангах, төрөл төрөгсөдөд нь эд материалын тусламж үзүүлдэг зэргийг нэрлэж болно. Настангуудад хоёроос дээш тэтгэвэр олгож буй агаад эхнийх нь өндөр насны тэтгэвэр, харин хоёр дахь нь ажилласан жилд нь олгох тэтгэвэр юм. Ингээд тэд урьд ажиллаж байсныхаа цалингийн 80 хувийг тэтгэвэрийн замаар авах боломжтой болсон бөлгөө. Монголын уул уурхайд үндэслэсэн эдийн засгийн 2011 оны 17.8 хувийн дундаж өсөлт байнгын бус байсан бөгөөд түүхийн эдийн дэлхийн зах зээлийн үнэ-ханш тогтмол эргэх мөчлөг, үе шаттай явагддаг, хамгийн гол нь энэхүү хөөсөн өсөлтөд тун болгоомжтой хандах учиртай байв.

*Тавд*, Сүүлийн хэдэн жилд эрчим хүч, дулааны салбарыг хувьчлах тухай салбарын яам нь бодлого болгон ярих болсон. Учир нь ингэснээр өрсөлдөөн буй болж үнэ буурах ажээ. Түлш, шатахууны салбарыг хувьчилснаар өрсөлдөөн өрнөж, үнэ буурсангүйгээр үл барам харин ч монопольт цөөн компаниуд үгсэн хуйвалдаж, зах зээл дээр зохиомлоор үнэ хөөрөгдөж буй нь улс орны нийгэм-эдийн засаг, иргэдийн амьжиргааны түвшинд томоохон бодит эрсдлийг буй болгосоор байгаа билээ. Ийм эмзэг эдийн засагтай байхад л үсрэнгүй хөгжлийн тухай хий хоосон чанга дуугарах ямар шаардлага байгаа нь ойлгомжтой. Цөөн хүн амтай, жижиг эдийн засагт чөлөөт өрсөлдөөн хэзээ ч буй болдоггүй. Үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, үсрэнгүй хөгжилд гол нөлөөтэй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах асуудал тун хожуу, гэхдээ дөнгөж шийдэгдэх төлөвтэй байгаа нь улс төр-бизнесийн ашиг сонирхолтой холбоотой байж таарна.

Дэлхийн газрын тосны үнийг тодорхойлогч ОПЕК олборлолтоо бодлогоор хязгаарлаж, мөн АНУ Ираны эсрэг хориггоо шангалсан нь дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ мэдэгдэхүйц өсөхөд нөлөөлж, 2019 оны 7 дугаар сарын 20-ны байдлаар Brent маркийн нэг баррель газрын тосны үнэ 63.26 орчим ам.долларт хэлбэлзэж, энэхүү үнийн өөрчлөлтийг дагаж Монгол Улсад бензин шатахууны үнэ өөрчлөгдсөөр байна.

Монгол Улс ОХУ-аас жилдээ 900-1500 сая ам. долларын өртөг бүхий 1500 мянган тн шатахуун худалдан авч, дотоодын хэрэгцээг хангадаг. Газрын тосны бүтээгдэхүүний импортыг өнгөрсөн 2018 оны бүтцээр нь авч үзвэл 90-ээс дээш

октантай автобензин 27 хувь, 90-ээс доош октантай автобензин 4 орчим хувь, дизель түлш 50 хувь, онгоцны түлш 2 хувь, үлдсэн нь (тос тосолгооны материал, мазут, хий) 17 хувийг эзэлсэн байна. Харин Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний нийт импортын 95 орчим хувийг ОХУ, 4.6 орчим хувийг БНСУ, 2 хүрэхгүй хувийг БНХАУ-аас импортолсон байдаг. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ сүүлийн таван жилд 66 хувиар өссөн бол тээврийн хэрэгслийн оношилгоонд хамрагдсан нийт автомашины тоо 53 хувиар өсчээ. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ ийнхүү жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд ердөө ганц ширхэг тээврийн хэрэгсэл нэмэгдэхэд л шатахууны хэрэглээ өдөрт 6 литрээр тооцоход л жилдээ дунджаар 1.8 тонноор нэмэгдэж байдаг тооцоо гарчээ.

Дэлхийн зах зээл дээр Brent маркийн нэг баррель газрын тосны үнэ 2014 оны 5 дугаар сард 115 ам. долларт хүрсэн нь түүхэн дээд амжилт<sup>6</sup> болсон билээ. Гэтэл энэ үед Монголд зөвхөн АИ-92 бензин литр нь дундажаар 1,670 төгрөг л байжээ. Засгийн газар татварын түвшнийг өөрчлөх замаар шатахууны үнийг тогтворжуулж байсан бөгөөд 2014 оны 4 дүгээр сард тухайлбал АИ-92 бензин литр нь 1,670 төгрөг, 2015 оны 4 дүгээр сард 1,660₮, 2016 оны 4 дүгээр сард 1,580₮, 2017 оны 4 дүгээр сард 1,630₮-өөр мэдэгдэхүйц өсч, буурч байжээ.<sup>7</sup> Гэтэл эдүгээ Brent маркийн газрын тосны нэг барреллийн дэлхий зах зээлийн үнэ 63.2 ам. доллар болчихоод байхад жишээ нь Монголд АИ-92 бензины үнэ литр тутам нь 1,840 төгрөг байгаа нь нэн хачирхалтай. Тиймээс ч шатахуун импорлогчид үнэ хөөрөгдсөн хэвээр, Ашигт малтмал, газрын тосны газар түүнтэй эвлэрсэн хэвээр, харин Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хүчин мөхөсдсөөр байгаа юм.

Иргэд, бизнес эрхлэгчдийг туйлдуулж буй том дарамт бол төгрөгийн ам.доллартай харьцах ханш мөн бөгөөд 1992 онд 1 ам. доллар 40 төгрөгтэй тэнцэж байжээ. Цаашаа явсаар ам. доллар-төгрөгийн харьцаа 1997 онд 447.63₮, 2001 онд 1,021.81₮, 2005 онд 1,146.53₮, 2009 онд 1,170.4₮, 2013 онд 1,265.5₮, 2016 онд 2,147.74₮, 2017 онд 2,440.63₮, харин 2019 оны 7 дугаар сарын 27-ны байдлаар 2,665.32 төгрөгтэй тэнцэж байгаа нь Монгол Улсын үндэсний валют сүүлийн 27 жилийн хугацаанд 67 дахин суларсан үзүүлэлт болж байна.<sup>8</sup> Хэдийгээр Монгол Улс 2018, 2019 онуудад эдийн засаг сэргэж, 2019 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 8.6 хувьтай гарч, Монголбанкны гадаад валютын албан нөөц нэмэгдэж 4 тэрбум долларт хүрсэн ч<sup>9</sup> төгрөг валютын эсрэг жилээс жилд ийнхүү суларсаар байгаа нь мөнгө, макро эдийн засгийн бодлого алдаатай хэрэгжсээр буйг харуулж байна. Төгрөгийн ханшны сулралтад Оюутолгойн хөрөнгө оруулалт ямар ч эерэг нөлөө үзүүлж байгаагүй бөгөөд цаашдаа үзүүлэх ч үгүй болов.

Монголбанк хуулийн дагуу хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулах ёстой

<sup>6</sup> 5 Year Crude Oil Prices and Price Charts. <http://www.infomine.com/investment/metal-prices/crude-oil/5-year/>

<sup>7</sup> Үндэсний Статистикийн Хороо. Инфляц, үнийн өөрчлөлт: Танилцуулга-2017

<sup>8</sup> Монголбанкны мэдээлэл. 2019.07.17

<sup>9</sup> Монголбанкны мэдээлэл. 2019.07.25. Гадаад валютын нөөц 4 тэрбум ам. долларт хүрэв.

байтал 2012 оны 10 дугаар сарын 22-нд Засгийн газартай “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг байгуулсан байдаг. Үүний хүрээнд “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр, “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах” дэд хөтөлбөр, “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр, “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр, “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” дэд хөтөлбөр, “Ипотекийн санхүүжилтын тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах Харилцан ойлголцлын Санамж бичиг” зэргийг хэрэгжүүлжээ. УИХ-ын харьяа байгууллага нь ингэж гүйцэтгэх засаглалтай өвөр түрийндээ орж бараг 4 орчим их наяд төгрөгийг ямар ч хараа хяналтгүй, дур зоргоороо зах зээлд нийлүүлсэн. Ингэснээр төрийн мөнгөний бодлого алдагдаж, их хэмжээний мөнгийг эрх мэдэлтнүүд төсвийн гадуур эмх замбараагүй хуваарилан зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Мөнгөний бодлого боловсруулах ёстой Монголбанк мөнгөнийхөө бодлогыг өөрсдөө дампууруулсан нь төгрөгийн ханш хяналтгүй унах үндэс суурийг тийнхүү тавьсан юм.

Монгол Улсын гадаад өр 29.5 тэрбум ам. доллараар хэмжигдэж байгаа нь<sup>10</sup> эдийн засагт дарамт болсоор байна. Монгол Улсын Засгийн газраас гадаад өрийг бууруулах нь валютын ханшийг бууруулахад нөлөөлдөг гэж үзэж байгаа бөгөөд 2021 онд “Хуралдай” бондын 500 сая, 2022 онд “Чингис” бондын 1 тэрбум, 2023 онд “Тэрэгэ” бондын 800 болон 600 сая ам.долларын өр төлөх ажээ. Өөрөөр хэлбэл, дөрвөн жилийн хугацаанд 2.9 тэрбум ам.долларын өр төлөх юм. Сангийн яамнаас энэхүү өрийн төлөх хугацааг 10 жил болгон сунгахаар төлөвлөж, дөрвөн жилийн дотор гадаадад төлөх 2.9 тэрбум ам.долларыг 10 жилд хуваарилснаар валютын ханш өсөхөөс сэргийлнэ гэж тооцоолж байгаа ажээ. Сүүлийн гурван жилд ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр төсөв хийгээд төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлж санхүүгийн сахилга хариуцлага мэдэгдэхүйц сайжирч, эдийн засгийн өсөлт 8.6 хувьд хүрч, макро эдийн засаг тогтворжиж байгааг дурдах ёстой.

Үндэсний аюулгүй байдлыг ноцтой хөндөж, шинээр гарч ирж буй асуудал болсон үгсэн хуйвалдаж үнэ хөөрөгдөх, УИХ-ын гишүүд өөрсөддөө мөнгө төсөвлөж хууль батлах болсон нь эдүгээ 8 тэрбум төгрөгөөр хэмжигдэж, инфляцийг хөөргөхөд нөлөө үзүүлсээр байгаа хүчин зүйлүүдийн гол шалтгаан юм. Төрийн институци нүсэр байгаагийн шалтгаан нь улс төрийн намууд төрийн албыг 50:50 хувиар хувьчилж авсан 2008 оноос үүдэлтэй болой. Сүүлийн 4 жилд ажлын байр шинээр буй болсны гуравны хоёр хувь нь төрийн албанд орсноос харж болно. 81.7 сая хүн амтай ХБНГУ-д 16 яам байхад харин 3 сая хүн амтай Монгол Улсад үүнээс дутахааргүй яамд байгаа нь үүний нотолгоо юм.

<sup>10</sup> Монгол Улсын нийт гадаад өрийн статистик. Монголбанк. 2019/ I улирал

**Зургаад,** Монгол Улсын МАА-н өсөх буурах, мах, махан бүтээгдэхүүн дэлхийн зах зээлийн үнэ ханш, тэгэх тусмаа хоёр хөршөөс ч үл хамаарах агаад, 2019 онд малын тоо толгой 70 саяд тулж ирэв. 1990 оноос хойш Монголын хүн ам ойролцоогоор 30 хувь өссөн байхад малын тоо толгой 2.4 дахин өсчээ. 1990 оноос өмнө жилд 4.5 сая малыг хойд хөрш рүү хөлөөр нь экспортод гаргаж байв. Одоогийн байдлаар Монгол Улс БНХАУ, ОХУ, Вьетнамын чөлөөт бүс, Иран, Казакстан, Японд мах экспортолж байгаа юм. Малын тоо толгой 2018 оны эцэст 66.4<sup>11</sup> саяд хүрч өмнөх оныхоос 4.6 саяар өссөн нь эдийн засгийг төрөлжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх үлэмж нөөцийг бүрдүүлж байна. Дэлхийн банк “Монголын эдийн засагт 2017-2018 онд эдийн засгийн хүчтэй сэргэлт ажиглагдлаа” хэмээн дэлхий нийтэд зарласан. ХХААХҮЯ 2018 оны 8 дугаар сард махны экспорт 100 тэрбум төгрөгөөс давсан тухай мэдээлэл хийв. Засгийн газраас “Мах, сүүний анхдугаар аян”-ыг орон даяар өрнүүлж, махны экспортыг нэмэгдүүлж, 2020 он гэхэд жилд 100 мянган тоннд хүргэх зорилт тавьсан. Монгол Улс сүүлийн жилүүдэд жилд арав гаруйхан мянган тонн мах экспортолж байсан бол 2017 оноос махны экспорт огцом нэмэгдэж, 2017-2018 онд 28 мянган тонн үхрийн мах, 43 гаруй мянган тонн адууны мах экспортлохоор тогтоож, хонь, ямааны маханд экспортын хэмжээ хязгаар тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд 2018 оны эхний 6 сарын байдлаар 10 шахам мянган тонн дулааны аргаар боловсруулсан мах, 9 мянган тонн адууны мах, 800 тонн хонины болон ямааны мах, 620 тонн үхрийн мах, 500 тонн дайвар бүтээгдэхүүн нийт 20 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолжээ. 2018 оны эхний 6 сарын байдлаар мах, махан бүтээгдэхүүний экспортоос 110 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2,8 дахин нэмэгдсэн үзүүлэлт ажээ.<sup>12</sup> ХХААХҮЯ статистикийн мэдээг үндэслэн хамгийн сүүлд мэдэгдэхдээ: 2018 онд 54.9 мянган тонн мах экспортод гаргасан. Үүний 37.3 мянган тонн нь хөлдүү, 17.6 мянган тонн нь дулааны аргаар боловсруулсан байх бөгөөд энэ тоог малын тоо толгойд шилжүүлбэл 4-5 сая толгой мал экспортод гаргажээ. Монгол Улс 2018 онд экспортоос 160 орчим сая доллар буюу 400 орчим тэрбум төгрөгийн орлого олсон байна.<sup>13</sup> Гэхдээ махны экспорт огцом өсөхийн хэрээр дотоодын зах зээлд махны хомсдол буй болж үнэ 3 дахин өсч буй гажууд тогтолцоог өөрчлөх шаардлагатай. Эцсийн эцэст хүн амын амжиргаанд ноцтой нөлөөлж буй махны үний огцом өсөлт махны экспортын өсөлтийг зөвтгөж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Засгийн газар дэлхийн зах зээлээс огт хамааралгүй болох махны үнийг бүрэн зохицуулж чадах байтал тэгэж чадаагүй нь эдийн засгийн далд эрх ашиг, сонирхол, дургүйд хүчгүйн шинж болой. Мах, шатахууны үний хөөрөгдлөөс олсон үлэмж их мөнгө парламентын сонгуульд зориулагддаг нь тодорхой, энэ нь бараг зуршил болов.

**Долоод,** Эзнээ олоогүй хавтгайрсан амлалтын бодлого, төрийн нүсэр

<sup>11</sup> Малын тоо 66.2 сая толгойд хүрч өслөө. Үндэсний Статистикийн Хороо. 2018.12.28 <https://ikon.mn/n/16pk>

<sup>12</sup> ХХААХҮЯ-ны танилцуулга. 2018.06.23

<sup>13</sup> ХХААХҮЯ-ны танилцуулга. 2019.01.11

институцийн зардал төсвийн алдагдлыг гааруулж, улс орныг эдийн засгийг гүн хямралд түлхдэгийг ЕХ-ны гишүүн нилээд орны хүндрэл бидэнд сануулсаар буй. Өндөр хүүтэй зээлээр тараасан, ирээдүйд улсын өр болсон 21 мянган төгрөг бол амлалтын мөнгө болохоос халамжийн мөнгө биш байсан юм. Гэхдээ энэ мөнгө олон мянган өрхийн амьжиргаанд чухал нөлөө үзүүлснийг нотлох шаардлагагүй. Сайхь мөнгөөр ихэнх иргэд архи ууж буй тухай номлож байсан нь ихээхэн эндүүрэл байсан бөгөөд тэр нь нийгмийн маш өчүүхэн хэсэг байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Амлалтын мөнгийг хүүхдийн мөнгөтэй нэг болгосон нь хамтарсан Засгийн газрын арчаагүй үйлдэл, том нүгэл болсон. Сурлагын хөшүүрэг байж, 80 түүнээс дээш үнэлгээтэй оюутнуудад тэтгэлэг болж очвол сайхь 70 мянган төгрөг илүү үр дүнтэй байх атал хавтгайруулсан нь аанай л шинэ баян цээж өвчтэйн бэлэн жишээ болсон. 21 мянган төгрөгийн үнэ цэнэ үнийн хөөрөгдөл, инфляцитайгаа хамт аль хэдийн замхарсан. 2008 оны сонгуулийн дараа Засгийн газраа дангаараа байгуулсан бол 1.5 сая, харин амлалтаа биелүүлэхээр хамтарсан Засгийн газар байгуулагдчихсан учир хоёр намын амлалтыг нэгтгээд хувьцаагаа ч, мөнгөө ч авах ёстой байв. Хэлсэн амандаа эзэн болох нь хар толгойгоо хариуцлагаас мултлах улс төрчдийн том “соёл” мөн. Гэтэл амлалтаа биелүүлж чадахгүй гэдгээ ичих ч үгүй мэдэгдэж байсан билээ. Хамтарсан Засгийн газар сонгуулийн бүрэн эрхийн хугацаандаа амлалтаа биелүүлсэн бол монголчууд бүгд «саятан» болох байв. Тиймээс ч хууран мэхэлж, залилан хийж засаг төрийн эрхэнд гарсан улс төрийн том нам 2012 оны сонгуульд нэр дэвшүүлэх улс төр, ёс суртахууны ямар ч эрхгүй тухай олон нийт ихээхэн шүүмжилтэй ярилцаж байсан юм.

Сүүлийн жилүүдэд УИХ-ын гишүүд өөрсдийн нэр дээр мөнгө төсөвлөж, хууль батладаг уламжлал тогтсон бөгөөд жил дараалан геометрийн прогрессоор өсч ирсэн тэрбум, тэрбум төгрөгөөр дүүрэг, хорооны засаг дарга нарын хийх ажлыг шүүрэн авч гүйцэтгэдэг болсон нь үнэн. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын дампуурал, гишүүний хуулиар сонгуулийн тойргоо хувьчилж авах гэсэн санаархал юм. Ард иргэдэд олгож байсан 21 мянган төгрөгөөр биш, харин УИХ-ын гишүүдэд олгож буй мөнгөөр л стратегийн томоохон аж үйлдвэрийн парк, газрын тос боловсруулах үйлдвэр, эмнэлэг, сургууль, зам барьж байгуулах ёстой билээ.

Жижиг, дунд үйлдвэрийн тухайд баримталж буй бодлого ч ихээхэн алдаатай байгаа нь 1950-иад оны сүүлчээр Хятадад тунхагласан “их үсрэлт” хэмээх бодлогын хүрээнд бүх айл өрх гэрийнхээ шавар зууханд хүдэр хайлуулах ажил эрхэлснээр ган үйлдвэрлэлээр удалгүй Английг гүйцэж түрүүлэхийн үлгэртэй агаар нэг юм. Бүх хүнийг үйлдвэрлэгч болгох шаардлагагүй, тийм боломж ч байхгүй. Өрхийн аж ахуй, ЖДҮ нь хоёр өөр ойлголт болой.

Эдүгээ УИХ-ын эрхэм гишүүдийн талаас илүү хувь нь гэнэтхэн эмзэг бүлэгт багтах болж, тэд ЖДҮ-ийг дэмжих хөгжлийн сангаас нэг ижил форматаар хэдэн зуун сая, тэрбумаар нь зээл авсан нь жижиг бизнес эрхлэгчдийн эрх ашгийг уландаа гишгиж, эрх мэдэл, албан тушаалын давуу байдлаа хэтрүүлсэн тун ч ноцтой үйлдэл болов.



**Наймд,** Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг эрх зүйн зохицуулалтгүй, хяналтгүй зоргонд нь тавьсны харгайгаар орон нутаг эзгүйрч хоосон орон зай буй болов. Энэ газар хэний нүдэнд өртөж байгааг хэлүүлэх юун. Энэхүү шилжилт хөдөлгөөний уршгаар Улаанбаатарын унаган иргэдээс хөдөөний иргэд давамгайл болж, нийслэл гэр хорооллоор бүслэгдэж, хотын зам-гээвэр, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, усны хангамж, дулааны салбар ачааллаа даахгүй болж, хотын иргэд хэрээс хэд дахин хэтэрсэн агаарын бохирдолын гамшиг дунд амьдрах болов. Шаталт буй цагт утаа гардаг энгийн теоремыг нотлох шаардлагагүй. Гарц бол утаагүй түлш ч биш, зуух ч биш, харин нийслэл Улаанбаатарыг задалж, гэр хороолол, оюутны хотхоныг бодлогоор үе шаттай нүүлгэн шинэ Дархан шиг дэд бүтэц бүхий шинэ Улаанбаатар хэмээх дагуул бичил хотхоныг байгуулах, Хархорумд төр засгийн зарим байгууллагуудыг шилжүүлэн байршуулах явдал юм. Гэр хороололд нарны эрчим хүчийг суурилуулах, шалнаас халах дулаалгын (олон улсын) иж бүрэн томоохон төсөл зоримог хэрэгжүүлэх шаардлагатай болов уу. Бээжин хотын утааг багасгасан гол арга хэмжээ нь түүхий нүүрс түлэхийг хориглосон явдал билээ. Гэр хорооллыг бүхэлд нь инженерийг шугамтай холбох боломжгүй ч бололцоотой хэсгүүд байгаа юм. Түүнчлэн Богд хан уулын хэд хэдэн чиглэлд Улаанбаатар-Төв аймгийг шууд холбосон нүхэн хонгил гаргах шаардлагатай. Ингэснээр Улаанбаатарын нягтрал, агаарын бохирдлыг тууштай бууруулна. Төв аймгийн нэг хэсэг газар Улаанбаатар хотын нутаг дэвсгэр болох боломж ч бүрдэнэ. Ирээдүйд нийслэлд метроны болон трамвайн шугамын үндсийг тавих шаардлагатай. Судлаачдын дүгнэлтээр нэг саяаас дээш оршин суугчидтай хотод метроны шугам тавих нь ашигтай байдаг ажээ. Улаанбаатар хотыг Төв аймагтай нүхэн хонгилоор метрогоор, алсдаа Улаанбаатар-Хархорумыг хурдны галт тэргээр холбосон тохиолдолд нийслэлийн ачааллыг үлэмж хэмжээгээр бууруулж чадна. Хүний аюулгүй байдлын нэн чухал хэмжээс болсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, аюулгүй хүнсээр хангагдах эрх ноцтой зөрчигдсөөр байна.

Нийслэлийн гэр хороололд амьдарч байгаа айл өрхийг хүйтний улиралд сайжруулсан түлшээр хангахад 600 мянган тн түлш шаардлагатай. Одоогоор 130 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэн нөөцлөөд байгаа ажээ. Бэлтгэсэн түлшийг нийслэлд 500 гэрээт цэгээр айл өрхүүдэд худалдан борлуулахаас 40 нь нөөцлөлтийн агуулах байх бол үлдсэн нь гэрээт борлуулалтын цэг байх юм. Өөрөөр хэлбэл 400 өрхийн дунд борлуулалтын 1 цэг байх ажээ. Сайжруулсан шахмал түлшийг айл өрхүүдэд картаар худалдан борлуулах бөгөөд айл бүрийн сууц, зуух, хэрэглээнээс шалтгаалж худалдан авах хэмжээ харилцан адилгүй байна. Тиймээс өрх болгон 1 карттай байна. Тухайн картаар худалдан авалт хийхдээ пос машинд уншуулахаас гадна, тухайн картыг унших андройд утасны аппликэйшн байна. Энэ тохиолдолд худалдан авалт хийхэд ямар нэгэн хүндрэлт гарахгүй хэмээн тооцоолж буй нь нэн сайшаалтай. 2019-2020 оны өвлийг харах л үлдэв.<sup>14</sup>

<sup>14</sup> 130 мянган шахам түлш нөөцлөөд байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим хуудас. 2019.07.19  
<https://www.mne.mn/?p=9000>

*Есд*, Хүн төрөлхтөн дижитал оюун ухаанд суурилсан аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын босгон дээр нэгэнт ирлээ. XX зууны сүүлч, XXI зууны эхнээс харилцан хамааралд суурилсан globalization эргэлт буцалтгүй болж байгаа тухай ихээхэн ярьж бичиж байсан, харин эдүгээ дэлхий нийтийн хэмжээнд бүх салбарт digitization эргэлт буцалтгүй болсон тухай ярьж бичих болов. Үнэхээр бүх салбарт дижитал шилжилт явагдаж байна. Генетикийн түвшинд дижитал оюун ухаан бүтээхээс эхлээд асар том цахим хувьсгал өрнөж байна. Дубайн World Government Summit дээр хүний тархи болон түүний дижитал хувилбар хоёрын хооронд мэдээлэл солилцох хурдны тухай, тэдгээрийн нэгдлийн тухай өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнөх болов. *Blockchain* технологи хөгжлийн асар өргөн боломжийг нээлээ. Тэгвэл наад зах нь 20 жилийн дараа гэхэд технологийн хөгжлийн ямар ирээдүй биднийг хүлээж буй төсөөлөл тун бүрхэг байгаа юм.

Олон улсын эдийн засагт дижитал эдийн засаг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж өндөр технологийн үйлдвэр, хиймэл оюун ухаанд суурилсан суурь машины үйлдвэр, олон улсын худалдаа, төлбөр тооцоо, олон улсын банк, санхүү, хөрөнгийн шилжилт, хөрөнгийн бирж бүхэлдээ дижитал системд суурилж байна. АНУ-ын Ливерморийн үндэсний лабораторид 192 хүчирхэг хүчин чадал бүхий лазерын тусламжтай халуун цөмийн инерцийн гинжин урвал явуулснаар 500 тераваттын эрчим хүч гаргаж авахаар ажиллаж байна. Гэтэл 2006 онд гэхэд дэлхийн нийт хүн ам 16 тераватт эрчим хүч хэрэглэж байжээ. Нэг тераватт гэдэг нь 1 их наяд ( $10^{12}$ ) ватт ажээ.

Дипломат ажиллагаанд оролцогч сүбъектүүд өргөжиж, худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, санхүү, зээл, мэдээлэл-холбооны технологи, хүрээлэн буй орчин, экологийн асуудал шинэ үүрэг гүйцэтгэх болсон нь сонгодог буюу уламжлалт дипломат ажиллагаа дангаар эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй болов. Мөн digital diplomacy, digital secretariat, digital embassy, digital ambassador, online freedom хэмээх ойлголтууд буй болов. Facebook, twitter diplomacy улс орнуудын иргэдийн санаа бодол, сонгуулийн үйл явцад хүчтэй нөлөө үзүүлж эхлэв. Өнгөт хувьсгалын гол тулгуур хүч нь нийгмийн сүлжээ (social media network) юм.

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр хязгааргүй “тэлсэн” явдал юм. *Cyber space* хэмээх хүний оюуны бүтээл болсон тулааны энэ орон зай хүн төрөлхтний амьдралд онцгой өөрчлөлт гаргаж, цаашид ч олон онцгой өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Глобал орчинд бүх салбарт асар хурдацтай *digital transition, digitalization* явагдаж, *new business model, new markets* болон *job opportunities, pipenv, virtualenv, python* буй болж байна. *Blockchain* технологийн хөгжил асар өргөн боломжийг нээж, түүнд суурилсан үнэт цаас (*digital gold, cryptocurrency*), *Финтек (fintech)*, түүнчлэн зөвхөн ухаалаг байх нь хангалтгүй болж, хиймэл оюунд (*artificial intelengence*) суурилах нь эргэлт буцалтгүй боллоо. Өнөөгийн даяаршсан ертөнцөд мэдлэг өөрөө нэн чухал мэдээлэл болж, эргээд мэдээлэл нь нэн чухал мэдлэг болж байгаа явдал бөгөөд энэхүү эргэх орчилд судалгаа, дүн



шинжилгээ, эрсдлийн үнэлгээний ач холбогдол тасралтгүй өсөн нэмэгдэж байна. Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багсч байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, өөр өөр соёл иргэншил, эдийн засаг, эрхзүйн тогтолцоотой 200 гаруй улс гүрэн интернетийн дэд бүтцэд холбогдож хил хязгааргүй эдийн засэг, мэдээллийн нэгдсэн нэг орон зай болон хувирав. Их гүрнүүд гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмийг баримталж байна.

R&D-д хэн хөрөнгө оруулалт хийж, тэнд цахим хувьсгал (*e-revolution*) явагдаж байхад Монгол Улс шинжлэх ухаан, технологийн хөгжилд ДНБ-ийн дөнгөж 0.12 хувийг зарцуулж байгаа нь гайхмаар доогуур үзүүлэлт мөн болой. Хүн төрөлхтөн шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхитай болов. Мэдээлэл, холбооны технологи, өндөр технологийн дэд бүтэц, суурь байгууламж, нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интегралчлал, инновацичлал улс орны хөгжлийн гол хэмжүүр болов.

Мүн Жэ-ин БНСУ-ын 12 дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсны дараа Аж үйлдвэрийн IV хувьсгалын хороог байгуулав. Samsung Electronics мэдээлийн технологийн хөгжлөөр дэлхийд нэг, хоёрдугаар байранд орж байгаа бөгөөд android үйлдлийн Samsung Galaxy гол брэнд нь болж байна. “Korea Telecom”-ын мэдээлснээр өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд тулгуурласан мэдээллийн дэд бүтэц буюу суурь байгууламж цогц бүрдсэн нь Солонгосчуудын амьдралыг чанарыг үндсээр нь өөрчилж байгаа ажээ. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд интеграцлагдсан 45 мянган төрийн институци *e-government*-ийг нэгэнт буй болгож, энэ нь солонгосчуудад хамгийн хурдан шуурхай засаглалын үйлчилгээг санал болгож байна. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд холбогдсон 13 мянга гаруй дунд, их, дээд сургууль өндөр зэрэглэлийн чанартай *e-education* тогтолцоог буй болгожээ. 3.5 сая жижиг, дунд үйлдвэрлэгчид дижиталчлагдсан системд холбогдон *e-commerce*-т суурилсан *B-to-B*-гийн гарцтай болсон байна. Мэдээллийн технологид үндэслэсэн бизнесийн хувьсгал ажлын байрны зах зээлийг эрс өргөжүүлж, нэмэгдсэн өртөг илүү өндөр шингээсэн бизнесийг буй болгов. Өндөр хурдны сүлжээнд суурилсан *on-line* эмнэлгийн үйлчилгээ амьдралын чанарыг эрхгүй өөрчилж буй ажээ. Энэ бүгдийн үр дүнд шинэ мянганы эрин үеийн эхнээс Солонгос нь *e-Society*-г байгуулж байгаа ажээ.

АНУ-ын ҮНО (GNI-Gross National Income)-д эзлэх дижитал эдийн засгийн байр суурь тасралтгүй өсөн нэмэгдсээр байна. 2013 онд АНУ-д дижитал эдийн засгийн салбарт 300 тэрбум ам. долларын бүтээгдэхүүн, үйлчилгээг буй болгосон байх бөгөөд ойрын 10 жилд энэ үзүүлэлт 6.1 их наяд ам. доллараар хэмжигдэх

ажээ. *McKinsey and Co*-гийн судалгаагаар АНУ-ын 10 доллар тутмын 1 нь биет мөнгөн хэлбэрт байгаа бөгөөд үлдсэн 9 нь цахим хэлбэртэй байдаг байна. 2018 онд Их 20-ын бүлгийн эдийн засагт дижитал эдийн засгийн эзлэх байр 5.2 их наяд ам. долларт хүрчээ. 2017 оны байдлаар Их Британийн дижитал эдийн засаг ДНБ-ийн 9.3 хувьтай тэнцэж байжээ.

2013 оноос АНУ уул уурхайн хайгуулын ажилд 3 хэмжээст технологийг ашигласнаар байгалийн хий, газрын тос, шатдаг занарын олборлолтоор дэлхийд тэргүүн байрт гарч ирэв. Швед, Сингапур дижитал эдийн засагтай орнуудын хамгийн хүчтэй өрсөлдөгчид гэдгийг Дэлхийн эдийн засгийн форумын судалгаа харуулжээ. Скандинав, Азийн орнууд мэдээлэл, харилцаа холбооны технологийг хамгийн үр ашигтай хэрэглэж буй орнууд юм. Энэ үзүүлэлтээр Финланд *суравдугаарт*, Швейцарь *дөрөвдүгээрт*, харин АНУ *тавдугаарт* эрэмбэлэгдэж байна. Дэлхийн эдийн засгийн форумар мэдээлэл, харилцаа холбооны технологи нь дэлхийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийг тогтвортой байлгах гол түлхүүр гэдгийг онцолжээ. Ялангуяа дэлхийн эдийн засаг дахь 20 жилийн ноцтой хямралын дараа мэдээлэл, харилцаа холбооны технологи маш чухал гэдгийг улс орнууд хүлээн зөвшөөрч байна.

Мэдээллийн технологиор дэлхийд тэргүүлж буй Сингапур улсын дараа Азийн бар орнууд Өмнөд Солонгос, Тайвань болон Хонг Конг бичигджээ. Харин Канад шилдэг арвын тоонд багтаж байна. Дээрх судалгааг дэлхийн 138 оронд явуулсан ажээ. Мөн бизнес, дэд бүтэц, байгаль орчны салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологи хамгийн өргөн нэвтэрсэн байна. XXI зууны эхнээс глобал эдийн засгийн харилцаанд бүтцийн шинэчлэл явагдаж дижитал эдийн засаг гол үүрэг гүйцэтгэж, глобал шинж чанартай, гэхдээ маш хурдан өөрчлөгдөж байна. Дижиталчлал боловсролын салбарын өмнө цоо шинэ нөхцөл байдлыг буй болголоо. Америкийн дээд боловсролын салбарт дээхнээс загварын нэгэн чухал өөрчлөлт явагдаж байгаа нь коллежийн зорилго нь багш оюутанд мэдлэг олгох, зааварчилгаа өгөх бус, харин оюутан тус бүртэй үр дүнд хүрэхүйц бүхий л арга хэрэгслээр *сурахуйн процессийг үйлдвэрлэх, шинэ мэдлэг бүтээх, инновацийн чадавхийг бий болгох* явдал гэж үзэх болов.<sup>15</sup> Энэ нь багш төвтэй сургалтаас оюутан төвтэй сургалт, багш-оюутны *interaction* руу шилжих үйл явц юм.

Судалгаанд суурилсан их сургууль гэдэг нь мэдлэгийн менежментыг хэрэгжүүлж, хуримтлагдсан шинжлэх ухааны ололтыг зөв манипуляци хийж, дахин боловсруулж шинэ мэдлэг буй болгох замаар инновацийг хөгжүүлэх явдал юм. Times Higher Education сэтгүүл тэргүүлэх их сургуулиудыг шинжлэх ухааны судалгаанд оруулж буй хөрөнгө оруулалт, түүний чанар, үр дүнгээр эрэмбэлдэг. Технологийн салбарт Калифорни, Массачусетсын сургуулиуд тэргүүлж байгаа бол олон улсын харилцааны салбарт Жонс Хопкинс, Жоржтаун, Колумби, Лондоны эдийн засаг, улс төрийн шинжлэх ухааны сургуулиуд шинжлэх ухааны think tank

<sup>15</sup> Robert B.Barr, John Tagg. «From Teaching to Learning: A New Paradigm for Undergraduate Education»-*Change Magazine*. November/December 1995, pp. 145-146

институциуд юм.

Технологид суурилсан сургалтад интернетэд холбогдсон 3 хэмжээст дэлгэц хийгээд виртуаль орчинд *touchless haptic feedback* технологи ашиглах явдал хэдийн бодит байдал болов. Орчин үеийн шинжлэх ухаан бол мэдлэгийн олон салбарласан систем юм. Үүнтэй уялдан түүнд технологи-судалгаанд суурилсан олон талт аргагүй хэрэглэгдсээр байна. Зөвхөн оюутнууд гэлтгүй бүх салбарын сургалт, хурал зөвлөлгөөн, семинар, парламентын хуралдаан ч тэр гар утсыг байнга ашиглаж, өөрөөр хэлбэл гар утснаасаа шууд хамааралтай болов. Гар утас нэгэнт өндөр хурдны компьютер болсон учир сургалтыг хэрхэн, яаж гар утсан дээр суурилж явуулах вэ гэдэг асуудал шинээр гарч ирж байна. Тиймээс Монгол Улс дижиталчлалд хурдан шуурхай шилжилт хийж, дасан зохицож, урагшлах шаардлагатай болов.

**Арагт,** Ажил эрхлэлтэд томоохон өөрчлөлт гарсаар байна. ШУТИС-ийн геологийн анги амжилттай төгсөөд гүний уурхайд шууд ажиллахгүй, АУҮИС төгсөөд мэс засалч болчихгүй, олон улсын харилцаа төгсөөд элчин сайд болчихгүй, бизнесийн удирдлага төгсөөд компанийн захирал болохгүй. Програмчлалын анги төгссөн ч орчин үеийн технологийн ололтын давтан сургалтад шуурхай хамрагдах шаардлагатай болов. Тиймээс давтан сургалт, мэргэших, өндөр эрмбийн сургалтад хамрагдах, дадлагажих, туршлагажих зэрэг зохих хугацаа шаардлагатай нь мэдээж. Дижитал эрин үеийн хөдөлмөр эрхлэлт гэдэг шинэ нэр томъёо гарч ирлээ. Хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байрны тухай ярих болов. Монголд хамгийн том ажил олгогч нь эрх барьж буй улс төрийн намууд болсон нь үнэн билээ. Түүгээр ч зогсохгүй гол ажил олгогч нь БНСУ болов.

Сургууль төгсөгч “Sony” компанид ажилд орохдоо бүхий л ажил амьдралаа зориулахаар тангараг өргөдөг үе дуусгавар болж байна. Их сургууль төгсөгчдийн 1/3 хувь нь ажлын байраа тогтмол өөрчлөх болжээ. Түүнчлэн карьерын хугацаа ч 2 дахин багасав. Гэрээгээр эсвэл part time хэлбэрээр ажиллах хандлага өргөжиж байна. Үүнийг *gig economy* хэмээн нэрлэж буй ажээ. Давосын илтгэлд тэмдэглэсэнээр ойрын 5 жилд 5 сая ажлын байр устаж, харин дижитал эдийн засгийн 2.1 сая шинэ ажлын байр буй болж, 2025 он гэхэд шинээр ажилд орох залуучуудын 60 хувь нь өнөөдөр байхгүй ажлын байранд хуваарилагдах ажээ. Өөрөө өөртөө ажлын байр буй болгох боломж технологийн хувьсгалын үр дүнд үлэмж өргөжив.

Их, дээд сургууль төгсөгчдөд тавигдаж буй шаардлага нь мэдлэг, ур чадвар, хандлага, чин эрмэлзэлд төвлөрч байна. Ажил олгогчид төгсөгчдийн мэдлэг, ур чадвараас гадна хариуцлагатай байх, өндөр ёсзүйтэй байх, бүтээлч-ажил хэрэгч байх, зарчимч байх, багаар болон бие дааж ажиллах, өөрчлөлтөд зохицож хөрвөх, хариу барих чадавх зэрэгт анхаарлаа төвлөрүүлэх болов. Энэ нь их сургуулиуд мэдлэг, ур чадвар олгохоос гадна хандлагад суурилсан бие хүн болж төлөвших чанарыг (personality traits) суралцагсдад суулгаж өгөх явдал нэгэн зэрэг тавигдаж байна. Мэргэжилтэн бэлтгэдэг үе нэгэнт үеэ өнгөрөөв. Хуучин нийгмийн үед социалист бие хүнийг төлөвшүүлэх, социалист аж төрөх ёсыг хэвшүүлж, социалист

нийгмийн харилцааг боловсронгуй болгох тухай их ярьж бичиж байсан л даа. Тэр ч нэг их муу зүйл биш байжээ.

ЕБС төгсөгчдийн 80 орчим хувь нь их дээд сургуулиудад элсч байгаа судалгаа байдаг. Гэхдээ хүн болгон дээд боловсролтой болох нь тийм ч муу зүйл биш болов уу. Дижиталчлалын эрин үед хүн бүр бүрэн дунд боловсролтой байх биш харин хүн болгон их сургуулийн боловсролтой байх нь ердийн шаардлага болж байх шиг байна. Их сургуулийн боловсролтой төгсөгч ёс зүйтэй бие хүн болж төлөвших чиглэлд том алхам хийж буй бөгөөд асуудалд бодитой хандах, нийгэмд өөрийгөө зөв авч явах, хууль бус үйлдлүүдээс зайлсхийж, өрх гэрээ төвхнүүлэх үйлд ихээхэн тус дөхөм үзүүлж байна. Тухайлбал, гадаадад сурч хөдөлмөрлөж ажиллаж буй иргэдийн гэмт хэргийн зөрчилд холбогдогчдын дийлэнхи хувь нь боловсролын түвшингээс хамаарч байна. Дотоодод ч нэгэн адил. Солонгост эмэгтэй хүн их сургууль төгсөөд хүнтэй сууж, хүүхэд гаргаад зүгээр л айлын эзэгтэй болдог. Энэ бол их сургуулийн боловсролтой ээж байна гэдэг нь зүгээр л нийгмийн хөгжлийн чиг хандлага. Ясли, цэцэрлэгт зарцуулах мөнгөний тодорхой хэсэг залуу ээж нарт хуваарилагдсанаар хүүхэд ээжтэйгээ хамт байж гэр бүлд сайн хүмүүжил олж авдаг. Цалинтай ээж хөтөлбөр нь энэ чиглэлд тус дөхөм үзүүлэх эхний алхам байх болов уу.

Их сургууль төгсөгчид лангуун дээр сууж байна, үсчин хийж байна, жолооч хийж байна гэгчлэн янз бүрээр шүүмжлэн ярьдаг. Гэтэл яагаад дээд боловсролтой маркетингийн чадавхтай худалдагч, дээд боловсролтой ур чадвартай үсчин, дээд боловсролтой малчин, барилгчин байж болохгүй билээ. Өөр мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн ч давтан сургалтад хамрагдаж Тавантолгой, Оюутолгойд белаз машины жолооч хийж яагаад болохгүй билээ. Олон залуучууд их дээд сургууль төгсчихөөд гадаадын олон оронд янз бүрийн ажил хөдөлмөр эрхэлж байна. Гэвч тэднийг УИХ-ын эрхэм гишүүд боолын хөдөлмөр эрхэлж буй мэтээр ярьж хэлдгээ болих хэрэгтэй. Тэд Монголд ажлын байр байхгүй учраас л өөрсдийн хүсэл тэмүүлэл, шаардлагаар гадаадад ажиллаж байна. Тэд албадлага, шахалт шаардлагаар яваагүй. Зөвхөн Солонгост монголын 49 мянган иргэд<sup>16</sup> сурч, хөдөлмөрлөж, ажиллаж байгаа ажээ. Тэдний монгол руу гуйвуулж буй мөнгөн хөрөнгө жилд дундажаар 200 сая ам. доллараар хэмжигдэж байна. Энэ нь улс орны нийгэм-эдийн засаг, айл гэрийн амьдралд маш чухал нөлөө үзүүлж байна. Харин ээлжит зорилт нь тэднийг мэргэжлийн сертификатжуулах шаардлага урган гарч байна.

Их дээд сургууль төгсөгчдийн чанар муу байна, тиймээс ажилгүйчүүдийн эгнээнд нэгдэж буй тухай шагшин ярьдаг. Хамгийн гол асуудал төр засгийн шинжлэх ухаанд суурилагагүй бодлого явуулсны хар гайгаар эдийн засгийн тэлэлт хумигдаж тэр хэмжээгээр ажлын байр эрс хорогдож байгаа тухай огт ярихгүй байгаа юм. МҮХАҮТ, УИХ-ын эрхэм гишүүдийн өөрсдийнх нь тэмдэглэснээр 2012-2016 оны хооронд л гэхэд нийт 125 мянган аж ахуйн нэгжийн 60 мянга нь

<sup>16</sup> Монгол Улс дахь БНСУ-ын ЭСЯ-ны мэдээлэл.2018.11.20

буюу 50 хувь нь төр засгийн олихоогүй бодлогын уршгаар дампуурсан нь үлэмж тооны ажлын байрыг үгүй хийсэн явдал болсон. Жишээ нь, бараг 10 жил яригдаж буй Яармагийн 300 ортой IV төрөх эмнэлэг ашиглалтад орж чадаагүйгээс олон арван эмч, сувилагч, сэтгэлзүйч, асрагч болон бусад ажлын байрыг үгүй хийсэн байна. Өнөөг хүртэл нэг ч км төмөр зам тавьж чадаагүйгээс энэ салбарт маш олон ажлын байр буй болгох боломжийг алдав. Долларын ханшны өсөлтөөс гадаад худалдаа хумигдаж, тийнхүү ААН-үүд маш олон маркетинг, борлуулалт, гадаад харилцааны менежерүүдийн ажлын байрыг алджээ. Гадаадын хөрөнгө оруулалт хумигдаж, барилгын салбар зогсонги байдалд орсноор олон ажлын байрны боломж хаагдсан. Энэ нь эргээд эцэг эхчүүдэд хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг олоход асуудал үүсгэж буй. Өнөөдөр инженерийн мэргэжлээр төгсөгчид ажлын байраар хангагдаж чадахгүй байна. Их сургууль төгсөгчдийн 46 хувь нь ажилгүй байгаа бол мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг төгсөгчдийн 54 хувь нь ажлаар хангагдаж чадахгүй байна. Өнгөрсөн жилүүдэд засаглалын чанарын доройтол, улс төржсөн хийрхэл, шинжлэх ухаанд суурилагагүй төсөв, мөнгө, хөрөнгө оруулалт, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын алдаанууд бидэнд том сургамж болов. Мэргэжилд тохирсон ажил олдохгүй байна, цалин бага байна, дадлага туршлага байхгүй байна, ачаалал даахгүй байна гэх янз бүрийн тайлбар, мөн ажил голж, шилэх зэрэг олон хүчин зүйл, шалтгаанууд буй.

БНХАУ 2018 оноос оюун ухаан, ур чадвар импорлохоо зарлачихлаа. Тиймээс хятадын өндөр орлоготой салбарт монголчууд өрсөлдөж ажиллах боломж нээгдэж байна. Нөгөө талаас мэдээлэл нь өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил дэвшилд нөлөө үзүүлэх шийдвэрлэх хүчин зүйл болж байна. Тиймээс мэдээллийн технологийн аюулгүй байдлыг найдвартай хангах нь нэн чухал болж байна. Мэдээллийн нээлттэй ил тод байдлын баталгаа ч чухал.

**Арваннэгд**, Монгол Улс мөнгө угаадаг, мөн дамжлага суваг болсон тухай бага хөндөгддөг. Хадгаламж авдаггүй, зээл олгодоггүй хэрнээ үйл ажиллагаа явуулж буй гадны хөрөнгө оруулалттай гэх зарим банк, түүнчлэн банк бус санхүүгийн байгууллага, төрөл бүрийн сангууд ихээхэн анхаарал татдаг. Бохир мөнгөний эх сурвалж нь хууль бусаар хар тамхи, мансууруулах бодис, зэвсгийн наймаа, садар самуун үзүүлбэр, хүний наймаанаас олсон орлого, авлига, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигласнаас олсон орлого, үгсэн хуйвалдаж үнэ хөөргөх замаар олсон гэнэтийн ашиг, далд эдийн засгийн орлого, татвараас займчуулсан мөнгө, оюуны өмчийн эрх хулгайлснаас олсон орлого, кибер орон зайд банкны луйвар хийх, хөрөнгийн бирж дээр хууль бусаар мөнгө босгох, хуурамч мөнгийг жинхэнэ болгож солих зэрэг үйл ажиллагаанаас олсон их хэмжээний бэлэн мөнгийг санхүүгийн төлбөрийн харьцангуй биет, илүү том хэлбэрт шилжүүлэн бэлэн мөнгө, үнэт цаас, чек, алт, бараагаар сольж хууль ёсны болгох үйл ажиллагаа зэргээс үүдэлтэй. Ер нь угаасан бохир мөнгөний тодорхой хэсгийг парламент, ерөнхийлөгчийн сонгууль, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн, тэдний зохион байгуулсан жагсаал цуглаан, захиалгат аллагыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль зэрэгт ашигладаг хэмээн

судлаачид болон мэргэжлийн байгууллагууд үздэг. Эдүгээ уул уурхайн хөгжлийг дагаад асар их мөнгөн дүн хийгээд авлигын тухай яригдаж буй үед энэ асуудалд онцгой анхаарах ёстой. Хойд хөршид авилга, мөнгө угаасан, далд эдийн засгийн их хэмжээний орлого, татвараас зайлсхийсэн зэрэг томоохон гэмт хэргүүдийг холбооны аюулгүйн албадын оролцоотойгоор илрүүлсэн байдаг. Өмнөд хөрш энэ чиглэлд үлэмж амжилт олж буй.

**Саарал жагсаалт асуудал болов.** Ойрын 2 жилд Монгол Улсын өмнө тулгараад буй хамгийн том асуудал нь Үндсэн хуулийн өөрчлөлт, УИХ-ы сонгууль, Оюутолгойг тойрсон асуудал, Эрдэнэт боловч мөн саарал жагсаалтын асуудал болов Одоогийн байдлаар тус жагсаалтад Этиоп, Серби, Шри Ланка, Сири, Тринидад ба Тобаго, Тунис, Йемен, Пакистан, Багамын арал, Ботсвана, Гана, Камбож улсууд оржээ. Эдгээрийн дийлэнхи нь сайн засаглалгүй, иргэний дайн, бослого хөдөлгөөн, терроризм, хар тамхины хууль бус наймаа газар авсан хөгжиж буй буурай улс орнууд юм. Авлигалын индексээр ч ихэнх нь хамгийн сүүлчээр эрэмбэглэгдэж буй улсууд ажээ.

2019 оны 6 дугаар сард дурдсан улсууд FATF-ын (The Financial Action Task Force on Money Laundering) 40 зөвлөмжид хууль эрхзүйн орчноо нийцүүлсэн, үр дүн нь ямар байгаа талаараа тайлагнажээ. Монгол Улсын хувьд 2019 оны 8 дугаар сард Тайландад болсон Бүсийн хуралд (APG) тайлагнаж, 10 дугаар сард Парист болсон FATF-ын уулзалтаар шийдвэр гарч, Монгол Улс “саарал жагсаалт”-д орсноор хугацаатай үүрэг амлалт авахаар болов.

Саарал жагсаалтад орсон тохиолдолд гадаадын аливаа банк санхүүгийн байгууллагатай харьцахад хүндрэл учрах боломжтой. Учир нь Монгол Улс олон улсын стандарт, норм мөрддөггүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зөвлөмжүүдийг дагаж мөрддөггүй хэмээн үзэх бөгөөд иймээс гадагшаа болон дотогшоо хийх олон улсын төлбөр тооцоо, шилжүүлэгийн гүйлгээнд саатал гарах эрсэл буй. Гүйлгээ хийгдсэн ч хугацаа алдах, хөндлөнгийн хяналт шалгалт хийгддэг байна. Улсын зээлжих зэрэглэл буурч, төгрөгийн ам. доллартай харьцах ханшид нөлөөлж, дотоодын аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулахад зохих хүндрэл үүснэ. Гадаадын хөрөнгө оруулалт ч саарах боломжтой. Саарал жагсаалтад орсон улсад хэн хөрөнгө оруулж, бизнес хийхийг хүсэх билээ. Эдгээр нь эргээд макро эдийн засгийн тогтворгүй байдал руу хүчтэй нөлөөлж эхэлнэ. FATF-ын шийдвэр зөвлөмжийн шинжтэй боловч хайхрахгүй өнгөрч үл болмой.

Монгол Улс саарал жагсаалтад орсон хэдий ч Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, ОУВС, Дэлхийн банк, Рио Тино корпораци хамтын ажиллагаагаа цаашид үргэлжүүлэхээ мэдэгдсэн юм.

Үйл явц 2001 оны 9 дүгээр сарын 11-нд Нью-Йоркт болсон олон улсын террорист халдлагаас үүдэлтэй. Өөрөөр хэлбэл террорист бүлэглэлийг хэн, ямар мөнгөөр, хэрхэн яаж санхүүжүүлсэн бэ гэсэн асуудал гарч ирсэн билээ. 2001 оноос хойш мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон улсын хэмжээнд



хууль, дүрэм, зөвлөмжүүд гарч эхэлсэн юм. Энэхүү мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг санхүүгийн хориг тавьдаг олон улсын гол байгууллага нь FATF юм.

Дэлхий нийтийн хэмжээнд бүс нутаг хариуцсан байгууллагууд үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Ази-Номхон далайн бүс нутгийг хариуцдаг нь байгууллага нь APG (The Asia-Pacific Group on Money Laundering) юм. 2004 онд Монгол Улс тус байгууллагад гишүүнээр элсч, 2006 онд УИХ Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхийн эсрэг Монгол Улсын хуулийг баталж, Санхүүгийн мэдээллийн албыг ч байгуулжээ.

2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын дараагаар уул уурхайн томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орж, эдийн засаг, улсын төсөв үлэмж хэмжээгээр тэлж эхлэв. Энэ нь өмнө нь их хэмжээний мөнгө харж байгаагүй олигополиудын сэрлийг хөдөлгөсөн нь үнэн билээ. Тэд гэнэт олдсон их мөнгөө хэрхэн нуух, яаж зарцуулахаа сайн ухааралгүй гадаадад үнэтэй байшин худалдан авч, суварга бариулж, хурдан морьд худалдан авч уралдуулж, урлагын бүтээл цуглуулж, сонгуулийн кампанит ажилдаа зарцуулж, албан тушаал худалдан авч, шүүх, хууль хяналтын байгууллагад нөлөөгөө тогтоож эхэлсэн гэж үздэг. Гэтэл энэ нь мөнгө угаалтын хамгийн энгийн арга, хэлбэрүүдийн нэг байжээ. Дээгүүр толгойтой нь оффшор бүсэд компани байгуулж, татвараас зайлсхийж мөнгө угааж байсан гэж тайлбарлах нь буй.

2012 онд Монгол Улс саарал жагсаалтад орсон билээ. Монголчууд ямар байгууллагад элсэж байгаагаа ч ойлгож амжилгүй саарал жагсаалтын сөрөг үр дагавар хэрхэж болохыг дөнгөж л тэр үед ойлгожээ. Тухайн үед Монгол Улс саарал жагсаалтад ороход Европын банкууд Монголтой харилцаагаа зогсоож, харин муу хэлдэг Хятадын банкаар дамжуулан өндөр шимгэлтэй, хяналт өндөр ч гүйлгээгээ хийж байжээ.

Ази, Номхон далайн бүс нутгийг төлөөлсөн APG нь FATF-н 40 зөвлөмжийг хуульдаа хянаж, нийцүүлсэн эсэхийг нь хянаад ийм шийдвэр гаргасан хэрэг ажээ. Мэдээж алдааг засч болно. Тус байгууллага Монгол Улсад 2013 оны 6 дугаар сарын 1-н хүртэл хугацаа өгч байжээ. Яг өмнөх өдөр нь буюу 2013 оны 5 дугаар сарын 31-нд УИХ-аар хурлаар Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн шинэчилсэн найруулгыг амжиж баталж байжээ. 2016 оны 11 дугаар сараас 2017 оны 6 дугаар сар хүртэл Ази, Номхон далайн бүс нутгийг төлөөлсөн APG-аас Монголд дахин үнэлгээг хийсэн юм. Энэ удаад тухайн зөвлөмжийг хууль дүрэмдээ тусгасан эсэхийг нь тусгаад үр дүн нь хэрхэн гарсныг нь шалгахаар болов. Үнэлгээний тайлан маш муу гарав.

Монгол Улсын үнэлгээ тааруу гарсан нь дурдсан бүх хугацаанд Монгол Улсад эрх бүхий цагдаа, шүүхийн байгууллагаар мөнгө угаах гэмт хэргээр ялласан тохиолдол гараагүй байна. Өөрөөр хэлбэл өнөөх бидний дагаж мөрдөж байгаа хууль нь FATF-н 40 зөвлөмжид нийцэхгүй байна л гэсэн үг. 2006 оноос хойш

мөнгө угаах, авлигалын шинжтэй олон зүйлс ил болсон билээ. Үүнд: Оюутолгойн гэрээний асуудал, оффшор данс, гишүүдийн гадаадад худалдан авсан үл хөдлөх хөрөнгүүд, бондын зарцуулалт, Хөгжлийн банк, Эрдэнэтийн 49 хувийн худалдан авалт, 51 хувийг барьцаанд тавьсан асуудал, Монголбанкны ажилчид хувьдаа ББСБ-тай гэсэн мэдээлэл, 60 тэрбумын асуудал, Монголдоо томд тооцогдох арилжааны нэжгээд банк дүрмийн сангийн босгоо хангасан үндэслэлээ нотолж чадаагүй байдал, ЖДҮ-ийн асуудал, 33 их наядын асуудал эдгээр болно.

АТГ хэмээх өндөр цалин хангамжтай УИХ-ын бүтцэд ордог энэ институци улс төрөөс ангид байж, хууль, шударга ёс, хүний эрхийг дээдлэх зарчмыг тууштай баримтлан үйл ажиллагаагаа шударга явуулах шаардлагатай. Өмнө нь орлогын мэдүүлэг бүртгэх, сонин хэвлэлд гарсан мэдээ, мэдээллийн мөрөөр ажлаа явуулдаг, жижиг жараахай лугаа тэмцдэг гэж олон нийт ихэнхдээ бухимддаг байсан билээ. Авилга өгөх, авах үйл ажиллагаа төрийн нууцаас ч нууц байдаг нь ойлгомжтой болсон байна.

АТГ-ын өмнөх дарга Х.Энхжаргалын мэдэгдсэнээр бол УИХ 2015 онд “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай” хуулийн хүрээнд 8.794 иргэн, 25.069 аж ахуйн нэгж, 448 иргэний болон мөн бондын нийт 33.3 их наяд төгрөгийн хөрөнгийг ил болгож Өршөөлийн хуульд хамруулсан нь Монголын нэр хүндийг олон улсын байгууллагад тун ч таагүй харагдуулсантай холбоотой хэргийг шалгаж, эздийг нь тогтоох асуудал байгаа билээ.

Нэгэнт үнэлгээний үр дүндээ муу тавиулчихсан учир засах хугацааг өгчээ. Шалгуулах хугацаа нь 2018 оны 10 дугаар сар байсан боловч бид дахин сунгуулаад 2019 оны 10 дугаар сар болгосон учир энэ ажгуу. Гэвч яаж ч хичээгээд 2019 оны 10 дугаар сард Парис хотноо хуралдсан FATF-ын Ерөнхий хуралдааны шийдвэрээр Монгол Улс Зимбабве, Исландын хамт “саарал жагсаалт”-д оров. FATF-ын шийдвэр хэдийгээр зөвлөмжийн шинж чанартай боловч Монгол Улсын гадаад нэр хүнд нөлөө үзүүлэхүйц том сануулга болов. Монгол Улс саарал жагсаалтад орсонтой холбогдуулан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагатай хариуцлага тооцсон ч Сангийн яам, Хуульзүй, дотоод хэргийн яам асуудлын гадна үлдэв.

Бидний анхаарлын гадна илэрхий орхигдож байдаг өөр нэг чухал асуудал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах тухай юм. АНУ, ОХУ, БНСУ, Япон, БНХАУ болон бусад орнууд үндэсний аюулгүй байдлыг хангахад тагнуулын байгууллагын ач холбогдлыг үзэл баримтлал, номлолдоо нээлттэй заасан байдаг. Тагнуулын байгууллагын чиг үүрэгт эдийн засгийн аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах, ялангуяа авилга, мөнгө угаах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх явдал чухал болж байна.

**Арванхоёрт,** Дээрхтэй холбогдуулан тэмдэглэхэд 2017 оны 5 дугаар сард УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдааны үеэр тус байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн Ш.Раднаасэдийн саналаар орсон гэх Эрүүгийн хуульд



хөөн хэлэлцэх хугацааг өөрчилсөн асуудал олон нийтийн анхаарлын төвд ноцтой өртөөд байгаа билээ. Энэ хуулийн өөрчлөлтөөр Хөгжлийн банктай холбоотой их хэмжээний мөнгө хөрөнгө шамшигдуулсан явдал, цаашлаад Эрдэнэтийн 51 хувийг Өмнөд Африкийн “Стандарт” банкинд барьцаанд тавьсан асуудал ч хэрэгсэхгүй болоход ойрхон байгааг хуульчид хөндөж эхэлсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид Эрүүгийн хууль тогтоомжийн гажуудлыг засах асуудлаар санал, дүгнэлт хүргүүлсэн юм. Тус арга хэмжээ авах тухай албан бичигт “... Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн илтэд зөрчилтэй, хийдэлтэй заалтуудаас шууд шалтгаалж мөрдөгч, прокурор, шүүгч нар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дур зоргоороо өөрсдийн үзэмжээр буруу тайлбарлан хэрэглэх зохисгүй практик бий болоход хүрч байна. Жишээ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрүүгийн хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал шүүгдэгч, ялганд ашигтайгаар шийдвэрлэх зохицуулалт тусгагдсан. Үүний хүрээнд авч үзвэл эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөлийг удирдлага болгон “Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тухайн шүүхээр хэргийг шийдвэрлэх хүртэл эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг тоолж, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх нөхцөл бүрдэн, улмаар ял завших боломжийг нэмэгдүүлсэн. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах өдрийг хүртэл тоолно гэсэн заалтыг хуулийн төсөл хэлэлцэгдэх явцад УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд тогтсон дэг, процедурыг зөрчин өөрчилж “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж өөрчилсөн. Ингэснээр авилгын болон эдийн засгийн гэмт хэргүүдийн мөрдөн шалгах ажиллагааг субъектив санаа зорилгоор хэт удаашруулж гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтнуудад ял завших боломжийг олгох хүндрэл үүсч байгаагаас гадна хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг шалтаг үндэслэлээр олон нийтийн анхаарлыг татсан цөөнгүй хэргүүдийг хэрэгсэхгүй болгох ноцтой нөхцөл бүрдээд байна. Сүүлийн үед авлигын гэмт хэргүүд, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, татвараас зайлсхийх болон эдийн засгийн зарим гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа хэт удаашралтай явагдаж, шүүхээс буцах, олон дахин хойшлогдох зэргээр процесс ажиллагааг нь зориуд сунжруулах явдал түгээмэл болж байгаа нь үүний нэг илрэл бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын оролцсон 25 хүнд холбогдох авлигын хэргийг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндэслэлээр шүүхээс хэрэгсэхгүй болгосон нь том нотолгоо боллоо...” гэжээ. Улмаар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болтол тоолно” гэснийг хүчингүй болгох, прокурор гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгохоор заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг хүчингүй болгох, нэмэлт хэргийн ангиллаар хөөн хэлэлцэх хугацааг тогтоох зэрэг санал дүгнэлт

оруулжээ.

*Арвангуравт*, 2015 онд баталсан НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 2030 зорилтыг үндэслэн 2016 онд батлагдсан «Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 он» баримт бичигт 2030 он гэхэд ядуурлыг ор мөргүй бүрэн арилгах тухай заажээ. Үндсэндээ 10 гаруй жил үлджээ. Гэхдээ ядуурлыг бууруулах, арилгах тухай бидний ойлголт өөрчлөгдсөөр байна. 2017 оны 11 дүгээр сард Өмнөд Вьетнамын Дан Нанг хотноо зохиогдсон АПЕК-ийн 25 дахь дээд уулзалтаас гаргасан Тунхаглалын хавсралт “Дижитал эрин үеийн хүний нөөцийн хөгжлийн үндэс” баримт бичигт дижитал эрин үед дасан зохицож хөрвөх, түүнд суралцахгүй ахул ядуурал улам нэмэгдэхийг онцлон тэмдэглэж, дижитал эрин үеийн боловсролын систем, давтан сургалтад онцгой анаарахыг чухалчлан заажээ.<sup>17</sup> 2017 оны Давосын эдийн засгийн форумд хэлэлцэгдсэн судалгааны “Олон улсын мэдээллийн технологийн тайлан”-д АНУ, Сингапур, БНСУ, Финланд, Голланд, Швед, Швейцарь зэрэг улсууд дижитал эдийн засаг болон дижитал инновациас хамгийн ихээр ашиг хүртэж байгаа ажээ. Энэ хандлага нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хооронд аль хэдийн буй болсон хөгжлийн зааг ялгааг улам бүр ихэсгэж, ядуурлыг нэмэгдүүлж байна гэж дүгнэжээ. Засгийн газар, бизнес эрхлэгчид болон их сургуулиуд дижитал технологийг хангалттай хэмжээгээр хөшүүрэг болгон ашиглаж чадахгүй байна гэсэн байна.

Мөнхүү үзэл баримтлалд 2030 он гэхэд Монгол Улс эрчим хүчнийхээ хэрэглээг 100 хувь өөрөө бие даан хангах тухай заажээ. Энэ зорилт ч биелэх магадлал ихээхэн эргэлзээ түрүүлсээр байна. НҮБ 2015 оны 9 дүгээр сард 193 гишүүн орныг нэгтгэсэн 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлт бүхий 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг баталсан байдаг. Дэлхийн улс орон бүр эдгээр зорилтыг үндэсний хөгжлийн төлөвлөлтийн үйл явц, бодлого, стратегидаа тусгах ажлыг хийсэн бөгөөд Монгол Улс ч “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийг батлан гаргасан. Гэвч Үндэсний хөгжлийн газраас хийсэн судалгаагаар манай улс НҮБ-ын дээрх зорилтуудаас 45 хувийг нь бодлогын баримт бичгүүддээ тусгаагүй гэсэн дүн гарч байгаа нь нэн харамсалтай бөгөөд ямаршуухан судалгааны түвшинд боловсруулагдсанаас харж болохоор байна.

*Арвандөрөвт*, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд гадаадад сурч, ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн аюулгүй байдал, сонгох, сонгогдох эрхийг хангах тухай ганц үг ган хийгээгүй билээ. Гадаад дахь монгол иргэдийн аюулгүй байдлын асуудалд анхаарлаа хандуулах нь Монгол Улсын төр, засгийн салшгүй үүрэг гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улсад сайн засаглал, тогтвортой хөгжлийн баталгааг хангахад магад дахиад олон арван жил шаардлагатай болов уу. Дэлхийн худалдаа-эдийн засаг, валют-санхүүгийн тогтвортой байдал Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх болов. Ойрын ирээдүйн томоохон сорилт нь дэлхий түүхий эдийн

<sup>17</sup> Annex B: APEC Framework on Human Resources Development in the Digital Era. [https://www.apec.org/Meeting-Papers/Leaders-Declarations/2017/2017\\_aelm/Annex-B](https://www.apec.org/Meeting-Papers/Leaders-Declarations/2017/2017_aelm/Annex-B)

зах зээл дээрх Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэс, алт, нүүрс, ноолуур, импортын шатахууны үнийн өөрчлөлт, валютын ханшны хэлбэлзэл, төлбөрийн тэнцэл, төсвийн алдагдал, гадаад өр, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, уламжлалт бус шинэ өвчний цар тахал, агаарын бохирдолт, хүний эрх, хууль дээдлэх, ардчилалын чанар алдагдах, ухаалаг засаглалын төлөвшил, өмнөд, хойд хөршийн тогтвортой хөгжил зэрэг болно. Даяаршлийн үйл явц өөрөө аливаа улс үндэстний аюулгүй байдлыг шалгах том шалгуур боллоо.

Өмнөх удирдагчийн гадаад дахинд ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хий хоосон сайрхан ярьж, бусдад зааж сургаж байх зуур Монголын эдийн засаг элгээрээ хэвтэж, улс төрийн систем нь гацаж, засаглалын чанар нь доройтолд орж, авилга цэцэглэн хөгжиж, иргэд нь утаандаа хордож, гадны шинжээчид Монголын баялгийн менежментийг муугийн жишээ болгон ярьж эхэлсэн билээ. НҮБ-ын индэр дээрээс “миний бодлоор бол монгол хүний цусанд ардчилал оршдог байх. Тиймээс ардчилал, эрх чөлөө бол монгол хүний мөн чанар мөн” хэмээн хийрхсэн лут дүгнэлт хийж билээ. Гуч гаруй жил бид бүхэн бүрэн ардчилагдчихсан, агуу их түүхтэй, асар их баялагтай, (200 жил ч идээд барахгүй) үсрэнгүй хөгжлийн ирмэг дээр ирсэн, сайн боловсролтой ард түмэнтэй, монгол ухаан, хосгүй монгол хүн гайхамшиг хэмээн цээжээ дэлдэж ирэв.

*Арвантавд*, Ардчилалын алтан хараацай гэж өөрсдийгөө өргөмжилсөн эрхэмүүд Монголд өрнөсөн ардчилсан үйл явцыг гадны ямар ч нөлөөгүй өөрсдөө аяндаа гэнэт гарч ирсэн юм шигээр тайлбарлахыг оролдсоор ирэв. Монгол Улсад өрнөсөн ардчилалын бодит уг сурвалж нь ЗХУ-д өрнөсөн улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалтын үйл явц, түүний Төв болон Зүүн Европ, улмаар дэлхий дахинд нөлөөлсөн өрнөлт шийдвэрлэх ач холбогдолтой байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Ойрмогхон хугацаанд уул уурхайд түшиглэсэн үсрэнгүй хөгжлийн *big bang* болоод өнгөрсөн. 2011 онд Монгол Улсын ДНБ-ий өсөлт бараг 17.8 хувьд хүрсэн нь дэлхийд байхгүй *гоц* үзүүлэлт болов. Үүнийг Монголын *гайхамшиг* төдийгүй дэлхийн эдийн засгийн хөгжлийн *phenomena* хэмээн нэрлэж байв. 2011 оны 7 дугаар сард Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг хатагтай Пратибха Девисингх Патил Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улсын эдийн засгийн дундаж өсөлт ирэх 2012 онд 22.9 хувьд хүрэхээр байгаа тухай Сангийн яамны албаны түшмэдээс дуулснаа Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Энэтхэгийн Аж үйлдвэрийн холбоо, Энэтхэгийн Худалдаа, аж үйлдвэрүүдийн танхимын холбоо, Энэтхэгийн Худалдаа, аж үйлдвэрийн нэгдсэн танхим хамтран “Kempinski Hotel Khan Palace” зочид буудалд зохион байгуулсан Бизнес форумд оролцож үг хэлэхдээ гайхан “биширч” байсан юм.<sup>18</sup>

Сайхь хөөсөн үзүүлэлт шинжлэх ухаанд суурилагагүй Засгийн газрын бодлого,

<sup>18</sup> БНЭУ-ын Ерөнхийлөгч Эрхэмсэг хатагтай Пратибха Девисингх Патилын Монгол Улсад хийсэн айлчлал. “Дэлхийн банкны судалгаагаар 2013 он гэхэд Монголын ДНБ-ий жилийн өсөлт 22.9 хувьд хүрэхээр байна” [unuudur.mn/2011.07.30](http://unuudur.mn/2011.07.30)

дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт, Хятадын эдийн засгийн удаашралаас замхран алга болсон билээ. Тиймээс ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд буй болсон эдийн засгийн 6.9 хувийн өсөлтийн эмзэг амжилтад тайвширч сайрхах, хөөрцөглөөд байх үндэслэл байхгүй юм.

**Арванзургаад,** Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 11 дүгээр сарын 27-нд бага насны хүүхдийг хүчирхийлсэн, амь насыг нь хөнөөсөн онц хэрцгий аллагын гэмт хэрэгтнүүдэд цаазаар авах ялыг сэргээх саналыг Хуульзүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэнтэй холбоотой асуудал юм. Цаазаар авах ялыг буй болгохтой холбоотойгоор онц хүнд гэмт хэргийн гаралт ноцтой буурдаггүйг нотолсон олон улсын судалгааг хүний эрхийн байгууллагууд иш үндэс болгодог. Тухайлбал, НҮБ-аас тусгайлан ажлын хэсэг гарч, 1988, 2000 онд цаазаар авах ял нь бүх насаар нь хорих ялаас илүү онц хүнд гэмт хэрэг бууруулдаггүй гэдэг дүгнэлт гаргаж байжээ. Канад улс цаазаар авах ялыг халснаас хойш 30 жилийн дараа хүн амины гэмт хэрэг 40 хувь, Энэтхэгт 7 жил цаазын ялыг хэрэглээгүй хугацаанд онц гэмт хэрэг 24 хувь буурсан гэсэн судалгаанууд байдаг ажээ.<sup>19</sup>

Монгол Улс цаазын ялыг хэрэглэхгүй гэдгээ 2010 оны 1 дүгээр сард зарлаж байсан, 2008-2012 оны УИХ 2012 оны 3 дугаар сарын 13-нд цаазаар авах ялыг халах, хэрэгжүүлэхгүй байх, сэргээхгүй байх үүрэг хүлээсэн Олон улсын гэрээ болох “Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Гэрээ”-ний II нэмэлт Протоколыг соёрхон баталжээ. 2012-2016 оны УИХ энэ алхмыг аанай л дэмжиж, 2015 онд шинэ Эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг албан ёсоор халснаар цаазын ялыг устгасан дэлхий 105 дахь орон болсныг Amnesty International байгууллага зарлаж байжээ. Цаазаар авах ялыг сэргээх нь хууль, эрхзүй болон процедурын шинжтэй асуудлыг гаргаж ирнэ гэсэн тайлбар ч байдаг байна. Учир нь II нэмэлт Протокол нь өөрөө гарах заалтгүй ажээ.

Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний ам нас буснилахыг хатуу хориглоно” гэж заасан байдаг. Ингэснээр Үндсэн хуулиараа цаазын ялыг хэрэглэх бүрэн боломжтой боловч салбар хуулиараа хязгаарлаж хаасан нь учир дутагдалтай гэж Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга үзсэн нь үндэслэлтэй юм.

Хууль батлах, нэмэлт оруулах нь УИХ-ын онцгой бүрэн эрхэд хадгалагддаг тул цаазаар авах ялыг Эрүүгийн хуульд тусгах эсэхийг УИХ шийдвэрлэх бүрэн боломжтой. УИХ Эрүүгийн хуульд зөвхөн энэ төрлийн /бага насны хүүхдийг хүчиндэх/ гэмт хэрэгт цаазаар авах ялыг тусгахаар шийдвэрлэсэн тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж

<sup>19</sup> О.Мөнхсайхан. Цаазын ялыг сэргээх ямар ч боломжгүй. 2017.12.01 <http://sodonmedee.com/>

мөрдөхгүй” гэсэн заалтын дагуу нэгдэн орсон конвенцийг мөрдөхгүй байх боломжтой ажээ.<sup>20</sup> Европын Парламент 2017 оны 2 дугаар сарын 15-нд гаргасан тогтоолд: Монгол Улсын цаазын ялыг халсныг сайшаасан байдаг.<sup>21</sup> Ер нь бол цаг нь болоогүй байхад Монгол Улс цаазын ялыг халсан бөгөөд үүнд өмнөх улс төрийн удирдагчийн субъектив хүчин зүйлс нөлөөлсөнд шүүмжлэлтэй хандагаа тэмдэглэх ёстой.

**Эцэст нь,** Монгол Улсын Үндсэн хуульт аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлд хийсэн нэг ололт нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт байв. УИХ-ын нэр бүхий 62 гишүүний 2019 оны 6 дугаар сард өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ дөрвөн сарын турш 36 удаа 105.9 цаг хэлэлцэн, 2019 оны 11 дүгээр сарын 14-нд УИХ-ын 64 гишүүний 100 хувийн саналаар батлав. УИХ-ын гишүүд төслийн танилцуулах хэлэлцүүлгийг 21 аймаг 9 дүүрэгт зохион байгуулж, иргэдээс 306 мянган санал иржээ. Төрийн ордонд олон өдөр үргэлжилсэн хэлэлцүүлгээр төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн нам, эрдэмтэн судлаачдаас 600 гаруй санал гарчээ. Эдгээр санал бүрийг нухацтай хэлэлцэж, өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг нийгмийн зөвшилцлөөр л өргөн хүрээг хамруулан батлав. Нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 28.5 хувь буюу 70 зүйлийн 19 зүйл, 36 заалтыг хөндсөн юм. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь Байгалийн баялагийг ашиглах зарчим, Парламентын ардчиллыг төлөвшүүлж, засаглах эрхийг хангахтай холбоотой, Гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой, Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт гэсэн дөрвөн хэсгээс бүрдсэн юм. 1992 оны Ардчилсан шинэ Үндсэн хуулийг орчин цагийн шаардлага, нийгмийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх асуудлыг олон нийт, улс төрийн хүрээнд сүүлийн 20 гаруй жилийн турш хөндөж, УИХ-ын гишүүд дөрвөн удаа төсөл өргөн барьж байжээ. Энэ удаагийн УИХ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталсан нь нийгмийн захиалгыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлсэн нэн чухал алхам болов.

2019 оны 11 дүгээр сарын 26-нд Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улс тунхагласны 95 жилийн ойн өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ёсчлон батлав. Хэдийгээр энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгохоос эхлээд олон зүйлсийг орхигдуулсан ч улс орны эрх ашиг, үндэсний эв нэгдлийг эрхэмлэх үүднээс Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг ёсчлох нь зөв хэмээн үзсэнээ Ерөнхийлөгч Х.Баттулга онцолсон юм.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны тавдугаар сарын 25-ны 12.00

<sup>20</sup> Ерөнхийлөгч Х.Баттулгын Мэдэгдэл. Ерөнхийлөгчийн ХМА. 2018.03.30

<sup>21</sup> European Parliament non-legislative resolution of 15 February 2017 on the draft Council decision on the conclusion of the Framework Agreement on Partnership and Cooperation between the European Union and its Member States, of the one part, and Mongolia, of the other part (08919/2016 – C8-0218/2016 – 2015/0114(NLE) – 2016/2231(INI))

цагаас эхэлж мөрдөнө.

Монгол Улс сүүлийн 30 гаруй жилд ардчилал, зах зээлийн замд томоохон амжилт олсон ч, үүндээ эрэмшсэн улс төрчид ардчилалыг өмчилж, улмаар түүний нэрээр халхавч хийж, Монгол шиг бүрэн ардчилагдчихсан, энэ чиглэлд үлэмж үсрэнгүй амжилт олчихсон, гайхмаар орон байхгүй юм шигээр авирлаж буй нь «коммунизм дахь “зүүний” нялхсын өвчин»-г эрхгүй санагдуулдаг. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга А.Амар 1934 оны хоёрдугаар сард хуралдсан МАХН-ын IX их хурал дээр хэлэхдээ: **«Бидний өчүүхэн бага монголчууд дэлхий дахины төлөөнөө санаа зовохоос урьд Монголын төлөө санаа зовбоос зохистой бөгөөд дэлхий дахины хэмээн өгүүлэхээс урьд Монгол хэмээн өгүүлвээс зохистой байх агсан амой»<sup>22</sup>** хэмээн дэлхийн хувьсгалын тухай лоозогнож байсан “зүүнтэн”-ий адал балмад үйл ажиллагааг илчлэн шүүмжилж байсныг сануулахад илүүдэх юун. Татах хүчийг үл хэрэгсэн өөрийн хөрснөөс жингүйдэн дэлхий дахинд ардчилалыг түгээх талаар хошууран ярих болсон нь ардчилал зарим талаар зар сурталчилгаа, шоуны шинжтэй болж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь яваандаа ардчилалыг хууль бус бусармаг үйлдлийг халхавчлах хэрэгсэл болгож байсныг анхаарах шаардлагатай. Эцэст нь, хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг хэрэгжүүлэх, хууль дээдлэх тогтолцоог төлөвшүүлж, төгөлдөржүүлэх нь хамгийн чухал нь болой. Зөөлөн хүчийг хүчилж хэрэгжүүлдэггүй, харин бишрүүлэн татах бүтээн байгуулалтаар буй болгодог ажгуу.

## НОМ ЗҮЙ

1. О.Мөнхсайхан. Цаазын ялыг сэргээх ямар ч боломжгүй. 2017.12.01 <http://sodonmedee.com/>
2. Ерөнхийлөгч Х.Баттулгын Мэдэгдэл. Ерөнхийлөгчийн ХМА. 2018.03.30
3. БНЭУ-ын Ерөнхийлөгч Эрхэмсэг хатагтай Пратибха Девисингх Патилын Монгол Улсад хийсэн айлчлал. “Дэлхийн банкны судалгаагаар 2013 он гэхэд Монголын ДНБ-ий жилийн өсөлт 22.9 хувьд хүрэхээр байна” unuudur.mn 2011.07.30
4. Annex B: APEC Framework on Human Resouces Development in the Digital Era. [https://www.apec.org/Meeting-Papers/Leaders-Declarations/2017/2017\\_aelm/Annex-B](https://www.apec.org/Meeting-Papers/Leaders-Declarations/2017/2017_aelm/Annex-B)
5. Монгол Улс дахь БНСУ-ын ЭСЯ-ны мэдээлэл.2018.11.20

<sup>22</sup> Намын IX их хурал. Нөхөр Амарын шүүмжилсэн шүүмжлэл. 24 он, II сар, 16 дахь тал